

**ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2025**

Судалгааг гүйцэтгэсэн:

Ж.Ариунцэцэг	судлаач
Б.Доржпагма	судлаач

ГАРЧИГ

УДИРТГАЛ	3
НЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	5
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСЭГ	6
2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсэг	6
2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсэг	7
2.3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсэг	8
2.4. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсэг	9
ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ДАГУУ ҮНЭЛСЭН БАЙДАЛ	10
3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал.....	10
3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал...	23
3.3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	35
3.4. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	40
ДӨРӨВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН	43
ХАВСРАЛТ.....	53

УДИРТГАЛ

Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль 2013 оны 4 сараас хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд түүнээс хойш 12 жил өнгөрчээ. Энэ хугацаанд хуулийн хэрэгжилтийн үр дагавар, нөхцөл байдал болон эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодруулах зорилготой судалгаа шинжилгээний ажлууд цөөнгүй хийгдсэн байна. Үүнээс дурьдвал, Япон Улсын Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА) болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн захиалгаар “Монголын хууль тогтоомжийн нийгэмлэг” ТББ нь 2015 болон 2020 онуудад хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгааг хийж гүйцэтгэсэн байна. Уг судалгаагаар “...өнөөг хүртэл энэ хууль амжилттай хэрэгжиж ирсэн...” гэх судалгааны ерөнхий дүгнэлт гарчээ. Түүнчлэн “Монгол Улсад шүүх дэх эвлэрүүлэн зуучлал болон шүүхээс гадуур бусад байгууллага дахь эвлэрүүлэн зуучлал байх холимог тогтолцоог хуульчилсан бөгөөд 2012 оны Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн гол цөм нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх, сайжруулахад чиглэгдсэн” хэмээн дүгнэжээ.

Мөн 2020 оны 5 сард ЕАБХАБ-ын Ардчилсан Институт Хүний Эрхийн Газар (цаашид “АИХЭГ” гэх)-аас Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн хүсэлтэд үндэслэн “Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ийн санал, дүгнэлт”-ийг боловсруулсан бөгөөд тус баримт бичигт “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 30.1-д зааснаас үзвэл Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль нь заавал шүүхээс санал болгохгүйгээр хийгдэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хамаарч буй эсэхийг тодруулах шаардлагатай байна. Монгол Улсад эвлэрүүлэн зуучлал хийх боломжийг нэмэгдүүлэхийн тулд хувийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хамруулах нь зүйтэй” гэх саналыг тусгасан байдаг. Өөрөөр хэлбэл төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооны дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа хэрхэн хэрэгжих талаар хуульд нарийвчлан тусгагдаагүй болохыг онцолж байжээ.

Иймд “Эвлэрүүлэн зуучлалын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх, эвлэрүүлэн зуучлалд хандах хөшүүргийг бий болгох хүрээнд УША-аар шийдвэрлэх маргааны төрлийг нэмснээс гадна хувийн эвлэрүүлэн зуучлалын үр дүнд байгуулсан гэрээг шүүхээр баталгаажуулах, хувийн эвлэрүүлэн зуучлах төвийг магадлан итгэмжлэх тогтолцоог нэвтрүүлэх, шүүхийн улсын тэмдэгтийн хураамжид хөнгөлөлт үзүүлэх, буцаан олгох зэрэг шинэ зохицуулалтууд тусгасан байна.

Тус судалгааны зорилго нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж, хуулийн төслийг боловсронгуй болгох санал боловсруулахад оршино. Тодруулбал, 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн “Хууль тогтоомжийн тухай” хуулийн

хэрэгжилтийг хангах үүднээс Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалыг баримтална. Судалгааг гүйцэтгэхдээ хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэх, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхийг зорилгоо.

Ийнхүү “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл” /цаашид хуулийн төсөл гэх/-ийн үр нөлөөг үнэлэхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх гэсэн үе шатыг баримтлан гүйцэтгэлээ.

НЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Хуулийн төслийн үр нөлөөний судалгааг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд тусгасан 6 шалгуураас нийт 4 шалгуур үзүүлэлтийг сонгож төслийн үр нөлөөг үнэллээ. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих байдал
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
4. Ойлгомжтой байдал гэсэн 4 шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн. Үүнд:

1. Хуулийн төсөл нь шүүхийн бус буюу төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төвүүдийн бүтэц зохион байгуулалт, чадавхи, мэргэшсэн байдлыг сайжруулж, эвлэрүүлэн зуучлах төвийн баталсан эвлэрлийн гэрээг баталгаажуулах зохицуулалт бий болгосноор шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалыг дэмжих эрх зүйн орчин бүрдүүлэх зорилгодоо хүрсэн эсэх;

2. Хуулийн төслөөр шүүхийн бус буюу төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төвүүдийн бүтэц зохион байгуулалт, чадавхи, мэргэшсэн байдлыг сайжруулахын тулд эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох хүрээнд Эвлэрүүлэн зуучлалын хороо гэсэн шинэ зохицуулагч бүтэц бий болгож, түүнд эвлэрүүлэн зуучлах төвийн магадлан итгэмжлэлтэй холбогдох үүрэг хариуцуулсан зохицуулалт болон шүүхийн бус буюу төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төвүүдээр дамжуулан батлагдсан эвлэрлийн гэрээний гүйцэтгэлтэй холбогдох эрх зүйн зохицуулалт практикт хэрэгжих эсэх;

3. Хуулийн төсөлд шинээр тусгагдсан төвүүдийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны чанарыг дээшлүүлэх, иргэдэд төвүүдэд хандах итгэл бий болгоход чиглэсэн магадлан итгэмжлэлтэй холбогдох зохицуулалт холбогдох этгээдүүдэд хүлээн зөвшөөрөгдөх эсэх;

4. Хуулийн төслийн зүйл, заалт нь хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой томъёологдсон эсэх зэргийг тус тусад нь авч үзэж, нэгтгэн дүгнэнэ.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСЭГ

Энэ хэсэгт хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, шалгуур үзүүлэлт бүрийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгов. Зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа гол ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуулийн төслөөс шинэ зохицуулалт бий болгож буй, гол ач холбогдол бүхий заалтуудыг сонгож, тухайн сонгосон зүйл, заалтын үр нөлөөг судаллаа.

Өмнө дурдсанчлан хуулийн төсөлд хувийн эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх, эвлэрүүлэн зуучлалд хандах хөшүүргийг бий болгох, хувийн эвлэрүүлэн зуучлалын үр дүнд байгуулсан эвлэрлийн гэрээг шүүхээр баталгаажуулдаг болох, эвлэрүүлэн зуучлах төвийг магадлан итгэмжлэх тогтолцоог нэвтрүүлэх зэрэг өөрчлөлтүүдийг тусгасан.

Тухайлбал, хуулийн төслөөр дараах асуудал буюу зохицуулалтуудыг шинэчлэн зохицуулах болон шинэ зохицуулалт бий болгохыг зорьсон байна. Үүнд:

- ✓ Эвлэрүүлэн зуучлалын зохицуулалтын тогтолцоо
- ✓ Эвлэрүүлэн зуучлалын төвийн зохион байгуулалт
- ✓ Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих арга зам
- ✓ Эвлэрүүлэн зуучлагчид тавих шаардлага
- ✓ Шүүхийн бус эвлэрлийн гэрээний гүйцэтгэл
- ✓ Шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар шийдвэрлэх маргааны төрөл
- ✓ Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хугацаа
- ✓ Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хураамж
- ✓ Эвлэрлийн гэрээний шаардлага, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нууцлал зэрэг болно.

Эдгээрээс эвлэрүүлэн зуучлах төвийн зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдох зохицуулалт болон эвлэрүүлэн зуучлалд хандах хөшүүрэг бий болгохыг зорьсон зохицуулалтуудыг голчлон сонгож, тохирох шалгуур үзүүлэлтүүдээр шалган үнэллээ.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсэг

Хуулийн төслийн үндсэн зорилго нь шүүхийн бус буюу төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх **эвлэрүүлэн зуучлах төвүүдийн** бүтэц зохион байгуулалт, чадавхи, мэргэшсэн байдал зэргийг сайжруулж, эвлэрүүлэн зуучлах төвүүдээр дамжуулан батлагдсан эвлэрлийн гэрээг баталгаажуулах зохицуулалт бий болгосноор шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалыг дэмжих эрх зүйн орчин бүрдүүлэхэд оршино.

Тиймээс энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд шинээр тусгагдсан, тус зорилгыг биелүүлэхэд чиглэсэн зохицуулалтууд зорилгодоо хүрэхүйц байгаа эсэхийг шалгана. Өөрөөр хэлбэл хуулийн төслийн эдгээр зохицуулалт шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын шинэ, үр нөлөөтэй зохицуулалтын тогтолцоог бий болгож, улмаар эвлэрүүлэн зуучлах төвүүдийн үйл ажиллагааг хөгжүүлэх түлхэц болж чадах эсэхийг авч үзэх юм. Үүнд:

Хүснэгт 1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлэх зүйл, заалт

№	Зорилгод хүрэх байдлыг үнэлэх зохицуулалт	Сонгосон зүйл, заалт
1	Хамрах маргааны төрлийг нэмэгдүүлэх зорилгоор УША-аар шийдвэрлэх маргааны төрлийг нэмэгдүүлсэн зохицуулалт	Хуулийн төслийн 6.5
2	Хувийн эвлэрүүлэн зуучлалын үр дүнд байгуулсан гэрээг шүүхээр баталгаажуулах боломжтой болгосон зохицуулалт	Хуулийн төслийн 31.1
3	Эвлэрүүлэн зуучлах төвийн зохион байгуулалт, үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг шинэчилж, магадлан итгэмжлэх тогтолцоог нэвтрүүлсэн зохицуулалт	Хуулийн төслийн 8.1; Хуулийн төслийн 8.3
4	Төвд ажиллах эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйч бус байх боломжийг нээсэн зохицуулалт	Хуулийн төслийн 14.1

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсэг

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд 1) эвлэрүүлэн зуучлалын хорооны бүтэц, зохион байгуулалттай холбоотой заалтууд, 2) эвлэрүүлэн зуучлалын хорооны бүрэн эрхтэй холбоотой заалтууд, 3) шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалтай холбоотой заалтууд, 4) эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангахтай холбоотой заалтууд, 5) эвлэрүүлэн зуучлах журмаар маргаан шийдвэрлэх харьяалалтай холбоотой заалтыг сонгон авч “Практикт хэрэгжих боломж”-ийг тооцсон болно. Сонгосон зүйл, заалтуудын дэлгэрэнгүйг хүснэгтээр үзүүлэв. Үүнд:

Хүснэгт 2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлэх зүйл, заалт

№	Практикт хэрэгжих боломжийг үнэлэх зохицуулалт	Сонгосон зүйл, заалт
1	Эвлэрүүлэн зуучлалын хорооны бүтэц, зохион байгуулалт	Хуулийн төслийн 9.1; Хуулийн төслийн 9.2; Хуулийн төслийн 9.3;

		Хуулийн төслийн 9.4; Хуулийн төслийн 9.6
2	Эвлэрүүлэн зуучлалын хорооны бүрэн эрх	Хуулийн төслийн 9.5
3	Шүүхийн бус эвлэрүүлэн зуучлал	Хуулийн төслийн 8.1; Хуулийн төслийн 8.2; Хуулийн төслийн 8.3; Хуулийн төслийн 8.4; Хуулийн төслийн 8.5
4	Эвлэрүүлэн зуучлах журмаар маргаан шийдвэрлэх харьяалал	Хуулийн төслийн 6.5
5	Эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангах	Хуулийн төслийн 30.1; Хуулийн төслийн 30.2

2.3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсэг

Өмнө дурдсанчлан хуулийн төслийг боловсруулах болсон үндсэн хэрэгцээ шаардлага нь шүүхийн бус буюу төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төвүүдийн бүтэц зохион байгуулалт, чадавх, мэргэшсэн байдлыг сайжруулахад оршино. Энэ хүрээнд эвлэрүүлэн зуучлагчийн чадавх, мэргэшсэн байдлыг сайжруулахад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг тусгаснаас гадна эвлэрүүлэн зуучлах төвийн үйл ажиллагааны үр нөлөө, чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн магадлан итгэмжлэх зохицуулалтыг шинээр тусгасан.

Иймд эвлэрүүлэн зуучлах төвийг магадлан итгэмжлэхтэй холбоотой зохицуулалт холбогдох этгээдүүдэд хүлээн зөвшөөрөгдөж хэрэгжих эсэхийг энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэв. Үүнд:

Хүснэгт 3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлэх зүйл, заалт

№	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Сонгосон зүйл, заалт
1	Эвлэрүүлэн зуучлалын төвийг магадлан итгэмжлэх	Хуулийн төслийн 10 дугаар зүйл

2.4. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсэг

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой томъёологдсон эсэхийг авч үзэв. /Хуулийн төсөл 6 бүлэг, 40 зүйлтэй./

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ДАГУУ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг Аргачлалд заасны дагуу дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 6.5 Хуулийн төслийн 31.1 Хуулийн төслийн 8.1; 8.3 Хуулийн төслийн 14.1	Эдгээр зохицуулалтыг хэрэгжүүлсэнээр хуулийн төслийн үндсэн зорилгод хүрэх байдалд дүн шинжилгээ хийнэ.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 9.1-9.6 Хуулийн төслийн 8.1-8.5 Хуулийн төслийн 6.5 Хуулийн төслийн 30.1; 30.2	Тухайн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийнэ.
3	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийн 10 дугаар зүйл	Тухайн зохицуулалт холбогдох хэрэгжүүлэгч болон хууль хэрэглэх этгээдэд хүлээн зөвшөөрөгдөх байдлыг судлана.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь	Хуулийн төслийн зүйл, заалт ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгасан.

Ийнхүү дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэллээ.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хуулийн төсөлд эвлэрүүлэн зуучлалын цар хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр юуны өмнө 3.1 дэх хэсэгт буюу хуулийн үйлчлэх хүрээнд Арилжааны эрх зүйн маргааныг нэмсэн. Түүнчлэн хуулийн төслийн 3.4-т эвлэрүүлэн зуучлалыг иргэний хэрэг үүсэхээс өмнө болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд хэрэглэж болохоор илүү тодорхой болгосон байна. Мөн тус заалтад Arb-Med /Арбитр-Эвлэрүүлэн зуучлал/ хувилбараар

явах боломжийг нээж өгсөн¹. Үүнд, шүүхэд иргэний хэрэг үүсгэсний дараа эвлэрүүлэн зуучлалд хандаж болдог шиг арбитрын хэрэг үүссэний дараа ч мөн эвлэрүүлэн зуучлалд хандаж, улмаар эвлэрсэн тохиолдолд арбитрын шийдвэрээр эвлэрлийг баталгаажуулдаг байх боломжийг нээлттэй болгожээ².

Төслийн 4.1.6-д “Эвлэрүүлэн зуучлалыг ашиглах тухай гэрээ, хэлцэл”-ийг шинээр оруулж өгсөн бөгөөд хэрэв талууд гэрээндээ маргаан үүссэн тохиолдолд эвлэрүүлэн зуучлалд хандах талаар тохиролцсон бол урьдчилан шийдвэрлэх ажиллагаа тогтоосон гэж үзэж, эвлэрүүлэн зуучлалд хандах талаар илүү тодорхой болгох зорилготой байна. Улмаар төслийн 6 дугаар зүйлд эвлэрүүлэн зуучлах журмаар маргаан шийдвэрлэх харьяаллын талаар, эвлэрүүлэн зуучлалаар маргаан шийдвэрлүүлэх хөшүүрэг болсон зохицуулалтуудыг нэмж тусгажээ. Тодруулбал, төслийн 6.2-т шүүхийн бус эвлэрүүлэн зуучлах төв нь газар нутгийн харьяалал харгалзахгүйгээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахаар тусгасан нь иргэдэд илүү сонголттой хувилбарыг бий болгоно.

Мөн төслийн 21.5-д шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө талууд эвлэрүүлэн зуучлалд хандаж, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд идэвх санаачилгатай оролцсон боловч эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй дуусгавар болсон бол шүүхийн улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг 25 хувиар бууруулж төлөх, хуулийн төслийн 21.6-д шүүхэд иргэний хэрэг үүсгэсний дараа, эсхүл шүүхийн аль ч шатанд талууд маргаанаа эвлэрүүлэн зуучлалд шилжүүлж улмаар талууд эвлэрэлд хүрсэн бол шүүхэд төлсөн тэмдэгтийн хураамжийг бүхэлд нь буцаан олгохоор заасан нь эвлэрүүлэн зуучлалд хандах байдлыг нэмэгдүүлэх зорилготой байна.

Түүнчлэн төслийн 15.3-д талууд цахимаар, утсаар холбогдох байдлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд биечлэн оролцож болох тусгаж, төслийн 21.7 болон 22.1-д эвлэрүүлэн зуучлах ажиллагаа талуудын хүсэлтээр цахимаар явуулах талаар зохицуулсан нь өнөөгийн нөхцөл байдал, олон улсын нийтлэг чиг хандлагад нийцсэн зохицуулалт тусгагдсан байна.

Тодруулбал, коронавирус (COVID-19) нь дэлхий нийтийн эрүүл мэндэд төдийгүй дэлхийн эдийн засаг, худалдааны харилцаанд нөлөөлж, томоохон өөрчлөлтүүдийг бий болгосон. Үүнд, бизнесийн харилцаанд талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөл байдал их хэмжээгээр үүссэний улмаас шүүхийн маргаан нэмэгдэхэд хүргэж, хэрэг маргаан шийдвэрлэлтийг хойшлуулах магадлал ихэнх оронд дагаад нэмэгдсэн байна. Ийнхүү хэрэг маргаан шийдвэрлэлт удаашралтай байгаа тул талууд маргаан шийдвэрлэх бусад төрлийн хувилбаруудыг (ADR) сонирхох болжээ. Улмаар коронавирусын тархалтын улмаас практикт хэрэгжиж эхэлсэн маргааныг онлайнаар

¹ Хуулийн төслийн танилцуулгаас.

² Мөн тэнд.

шийдвэрлэх (ODR) буюу Virtual ADR арга замууд вирусын хямралын дараа ч практикт хэвшин үлдэж байна³.

Иймд хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд эвлэрүүлэн зуучлалд хандах боломжийг олгож, эвлэрүүлэн зуучлалд хандах болон эвлэрсэн зэргээс шалтгаалан тэмдэгтийн хураамжийг бууруулан төлөх, буцаан олгох, цахим болон утсаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд биечлэн оролцох, мөн төвүүд газар нутгийн харьяалал харгалзахгүй маргаан хүлээн авах болсон зэргээс үзэхэд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг нийтлэг байдлаар дэмжих, тэр дундаа төвүүдийн үйл ажиллагааг дэмжихэд шаардагдах үндсэн өгөгдөл (хөшүүрэг) болох зохицуулалтууд зохих хэмжээнд тусгагдсан байна гэж дүгнэж болно.

Харин шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх, эвлэрүүлэн зуучлах төвд хандах хөшүүргийг тухайлан бий болгох хүрээнд юуны өмнө УША-аар шийдвэрлэх маргааны төрлийг нэмсэн. Үүнээс гадна хувийн эвлэрүүлэн зуучлалын үр дүнд байгуулсан эвлэрлийн гэрээг шүүхээр баталгаажуулах, эвлэрүүлэн зуучлах төвийг магадлан итгэмжлэх тогтолцоог нэвтрүүлэх, шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлагч эрх зүйч бус мэргэжилтэй байх боломж олгосон зохицуулалт төсөлд тусгагдсан. Ийнхүү төвийн үйл ажиллагааг дэмжих тухайлсан хөшүүрэг болсон дараах үндсэн зохицуулалтууд хуулийн төсөлд туссан байна. Үүнд:

1. Хамрах маргааны төрлийг нэмэгдүүлэх зорилгоор УША-аар шийдвэрлэх маргааны төрлийг нэмэгдүүлсэн

Хуулийн төслийн 6.5.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.4-т зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаан, түрээс болон эд хөрөнгө хөлслөх гэрээний маргаан, хөршийн эрхийн маргаан, сууц өмчлөгчдийн холбооны маргаанд эвлэрүүлэн зуучлалыг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар хэрэглэнэ.

2. Хувийн эвлэрүүлэн зуучлалын үр дүнд байгуулсан гэрээг шүүхээр баталгаажуулах боломжтой болгосон

Хуулийн төслийн 31.1.Төвийн эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ сайн дураар биелүүлээгүй бол эвлэрлийн гэрээ зөрчигдөж эхэлсэн үеэс үүрэг гүйцэтгэгчийн харьяа дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүсэлт гарган эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулна.

3. Эвлэрүүлэн зуучлах төвийн зохион байгуулалт, үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг шинэчилж, магадлан итгэмжлэх тогтолцоог нэвтрүүлсэн

Хуулийн төслийн 8.1.Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу тухайн салбарын эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх энэ хуульд заасан журмын дагуу магадлан итгэмжлэгдсэн эвлэрүүлэн зуучлах төв/цаашид “Төв” гэх/-ийг ажиллуулж болно.

Хуулийн төслийн 8.3.Төвийг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн

³ “Mediation Laws in Developing Nations”, <https://icmcrmediation.org/analyze-the-laws-of-developing-countries-in-the-field-of-mediation/>

Эвлэрүүлэн зуучлалын хороо/цаашид “Хороо” гэх/-ны саналыг үндэслэн магадлан итгэмжилнэ.

4. Төвд ажиллах эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйч бус байх боломжийг нээсэн

Хуулийн төслийн 14.1.Шүүхийн эвлэрүүлэн зуучлагч болон Төвийн эвлэрүүлэн зуучлагчид дараах шаардлага тавигдана:

14.1.1.эрх зүйн бүрэн чадамжтай байх;

14.1.2.дээд боловсролтой байх;

14.1.3.эвлэрүүлэн зуучлагчийн сургалтад хамрагдан гэрчилгээ авсан байх;

14.1.4.ял шийтгэлгүй байх/ял шийтгэгдэж байгаагүй.

Иймд дээрх зохицуулалтуудыг чиглэл тус бүрээр нь ач холбогдол, үр нөлөөг нь авч үзэж, улмаар эдгээр нь нийтдээ шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын шинэ, үр нөлөөтэй зохицуулалтын тогтолцоог бий болгож, эвлэрүүлэн зуучлах төвүүдийн үйл ажиллагааг хөгжүүлэх түлхэц болж чадах эсэхийг нийтэд нь дүгнэлээ.

1. Хамрах маргааны төрлийг нэмэгдүүлэх зорилгоор УША-аар шийдвэрлэх маргааны төрлийг нэмэгдүүлсэн зохицуулалтын ач холбогдол, үр нөлөө


Хуулийн төсөлд эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх маргааны хамрах хүрээг нэмэгдүүлэх үүднээс УША-аар шийдвэрлэх маргааны төрлийг нэмсэнээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.4-т зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаанаас гадна 1) түрээс болон эд хөрөнгө хөлслөх гэрээний маргаан, 2) хөршийн эрхийн маргаан, 3) СӨХ-д холбогдох маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх болж байна.

Хуулийн төслийн 6.5.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.4-т зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаан, түрээс болон эд хөрөнгө хөлслөх гэрээний маргаан, хөршийн эрхийн маргаан, сууц өмчлөгчдийн холбооны маргаанд эвлэрүүлэн зуучлалыг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар хэрэглэнэ.

Ач холбогдлын хувьд УША-аар шийдвэрлэх маргааны төрлийг нэмэгдүүлсэнээр эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх маргааны тоо шууд нэмэгдэх үр дагавартай. Гагцхүү хуулийн төслийн үндсэн зорилгод ямар хэмжээнд нөлөөлөх буюу хувийн эвлэрүүлэн зуучлалд хэдэн хувь нь хандахыг урьдчилан таамаглах нь чухал асуудал болж байна.

Энэ хүрээнд эдгээр маргааны төрөл шүүхээр шийдвэрлүүлсэн тоон мэдээллийг сүүлийн 3 жилийн хугацаанд авч үзвэл дараах тоон үзүүлэлт гарч байна. Үүнд:

**График 1. УША-р шийдвэрлэхээр нэмж тусгасан 3 төрлийн маргааны
шүүхээр шийдвэрлүүлсэн байдал, 2022-2024 он**



Эх сурвалж: ШЕЗ-өөс албан бичгээр *Иргэний хэргийн бүртгэл хяналтын
“Иргэн-2014” нэгдсэн систем”-ээс шүүж* ирүүлсэн тоон мэдээлэл

Үүнээс үзэхэд эд хөрөнгө хөлслөх гэрээтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэсэн тоо сүүлийн 3 жилийн дунджаар 9.6 буюу 10 хүрэхгүй байгаа бол СӨХ-той холбоотой хэргийг хянан шийдвэрлэсэн тоо хамгийн олон буюу 3 жилийн дундаж 746, харин түрээсийн гэрээтэй холбоотой хэргийг шийдвэрлэсэн тоо 3 жилийн дунджаар 643 байна.

Иймд 3 төрлийн маргааныг шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоогоор нь баримжаалан нэгтгэн авч үзвэл 1 жилд ойролцоогоор 1400 орчим тооны маргаан УША-аар орох буюу эвлэрүүлэн зуучлалд хандахаар нэмэгдэж байна⁴.

Харин эдгээрээс хувийн эвлэрүүлэн зуучлалд хэдэн хувь нь хандах тухайд шууд гаргах боломжгүй тул нийт маргааны тодорхой хувиар төвд хандах маргааны тоог таамаглан авч үзвэл хэдэн маргаан гарч байгааг хүснэгтээр харууллаа. Үүнд:

**Хүснэгт 4. УША-р шийдвэрлэхээр нэмж тусгасан 3 төрлийн маргааны шүүхээр
шийдвэрлүүлсэн байдал, тэдгээрийн дундаж**

Төрөл	1 жилд, 3 жилийн	5%	10%
-------	------------------	----	-----

⁴ Эдгээр нь зөвхөн шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоо бөгөөд үлдэгдэл буюу тухайн онд шийдвэрлэгдээгүй он дамжин үлдсэн маргааны тоо багтаагүй гэдгийг анхаарах нь зүйтэй.

	дунджаар		
СӨХ-ны маргаан	746	37.3	74.6
Түрээсийн гэрээтэй холбоотой	643	32	64.3
Эд хөрөнгө хөлслөх гэрээтэй холбоотой	10	0.5	1
Нийт	1400	70	140

Үүнээс үзэхэд төвд хандах маргааны тоо эхний жилүүдэд нэмэгдэж буй⁵ нийт маргааны 10%-д хүрэхгүй гэж үзвэл 5%-аар бодоход дор хаяж 70 маргаан хувийн эвлэрүүлэн зуучлалд хандах магадлал бий болж байна.

Хуулийн төслийн танилцуулгад түрээсийн гэрээ болон эд хөрөнгө хөлслөх гэрээтэй холбоотой маргааны талууд бусад төрлийн маргааны талуудтай харьцуулахад эвлэрэх магадлал өндөр байдаг тул энэ шинжид нь тулгуурлан урьдчилан шийдвэрлэх журмыг тогтоож өгсөн гэж тайлбарлажээ. Тэгвэл энэ 2 төрлийн маргааныг дээрх тоон үзүүлэлтээс нэгтгэн авч үзвэл түрээсийн гэрээтэй холбоотой 643 + эд хөрөнгө хөлслөх гэрээтэй холбоотой /10/ буюу жилд ойролцоогоор 650 хэрэг шийдвэрлэгдэж байна.

Гэсэн хэдий ч эдгээрээс хувийн эвлэрүүлэн зуучлалд хэдэн хувь нь хандах тухайд шууд таамаглах боломжгүй гэдгийг дахин дурдах нь зүйтэй. Хуулийн төсөлд зааснаар эвлэрүүлэн зуучлалын хөлсийг төв өөрөө, зах зээлийн зарчмаар тогтоох тул өндөр үнийн дүнтэй, бизнесийн нэр хүнд хадгалахыг хүссэн арилжааны маргаан болон нарийн мэргэжлийн ойлголт, мэргэжилтэн шаардах хэрэг маргаанууд эвлэрүүлэн зуучлах төвд хандах магадлал өндөртэй. Үүнийг манай улстай төстэй нөхцөл байдал үүссэн бусад орны туршлага ч харуулж байна. Үүнд:

⁵ Гэр бүлийн маргаан нь одоо эвлэрүүлэн зуучлалаар УША-аар шийдэгдэж байгаа тул зөвхөн шинээр нэмэгдсэн маргааны төрлийн магадлалыг авч үзэв.

Энэтхэг улсын туршлагаас:

Анх 1996 онд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хуульчилсан Энэтхэг улсад гэхэд эвлэрүүлэн зуучлалыг нэвтрүүлэх шатандаа явж байна гэж дүгнэж байна. Тус улс Монгол Улстай төстэй нь хэдийгээр тус улсын шүүх ачаалал ихтэй байдаг ч шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалыг найдваргүй гэж үзэх хандлага хэвээр байгаа тул шүүх эрх мэдлийн болон хууль тогтоох байгууллагаас нь сүүлийн жилүүдэд эвлэрүүлэн зуучлалыг сурталчлах алхамуудыг хэрэгжүүлэх болжээ. Гэхдээ тус улсад 1990-ээд оноос хойш арилжааны арбитрын ажиллагаа нилээдгүй тогтворжсон байна.

Хувийн эвлэрүүлэн зуучлал нь тус улсад талуудад төдийлөн хүлээн зөвшөөрөгдөхгүй хэвээр байгаа ажээ. Тэдний үйлчлүүлэгчид нь үндсэндээ өөрсдийн **нэр хүнд, бизнесийн байр сууриа хамгаалах зорилгоор** хувийн эвлэрүүлэн зуучлалыг сонгодог **үндэстэн дамнасан компани, фирмүүдээр** хязгаарлагддаг байна.

Эх сурвалж: “Эвлэрүүлэн зуучлалын талаарх хөгжиж буй орнуудын эрх зүйн зохицуулалтад хийсэн дүн шинжилгээ”, <https://icmcrmediation.org/analyze-the-laws-of-developing-countries-in-the-field-of-mediation/>

Өөрөөр хэлбэл УША-аар шийдвэрлэх маргааны төрлийг нэмэгдүүлснээр төвд хандах тоо нэмэгдэх шууд үр дүн гарахгүй гэж үзэж байна. Харин төсөлд туссан бусад зохицуулалтын үр дүнд төвүүд нь зах зээлийн зарчмаар, шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалд хандах давуу талыг бий болгосноор эвлэрүүлэн зуучлах төвд хандах тоо нэмэгдэх үр дүн гарна.

2. Хувийн эвлэрүүлэн зуучлалын үр дүнд байгуулсан гэрээг шүүхээр баталгаажуулах боломжтой болгосон зохицуулалтын ач холбогдол, үр нөлөө

Хуулийн төсөлд шүүхийн бус буюу эвлэрүүлэн зуучлах төвийн эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан эвлэрлийн гэрээг иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүсэлт гарган шүүгчийн захирамжаар баталгаажуулах тухай тусгасан.

Хуулийн төслийн 31.1.Төвийн эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ сайн дураар биелүүлээгүй бол эвлэрлийн гэрээ зөрчигдөж эхэлсэн үеэс үүрэг гүйцэтгэгчийн харьяа дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүсэлт гарган эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулна.

Ийнхүү эвлэрлийн гэрээ зөрчигдөж эхэлсэн үеэс анхан шатны шүүхэд хүсэлт гарган хувийн эвлэрүүлэн зуучлалаар байгуулсан эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулах боломжийг хуулийн төсөлд тусгасан байна. Энэ нь хувийн эвлэрүүлэн зуучлалд итгэх итгэлийг нэмэгдүүлж, эвлэрүүлэн зуучлах төвд хандах тоог нэмэгдүүлнэ гэж хууль санаачлагчийн зүгээс үзсэн байна. Үүнд, хувийн эвлэрүүлэн зуучлах төвд хандаж эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд байгуулсан эвлэрлийн гэрээний үүрэг зөрчигдөхөд албадлага хэрэглэх боломжгүй, дахин шүүхэд хандах нөхцөл байдал үүсдэгтэй холбоотойгоор хувийн эвлэрүүлэн зуучлалд хандаж маргаанаа шийдвэрлүүлдэггүй байна гэж дүгнэжээ⁶.

Тодруулбал, “2023 оны 12 дугаар сард хийгдсэн “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь” судалгааны тайлангийн дүгнэлт хэсэгт манай улс 2012 онд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг батлахдаа Олон Улсын Арилжааны Эвлэрүүлэн Зуучлал болон Эвлэрүүлэн зуучлалын үр дүнд хийгдсэн олон улсын эвлэрлийн гэрээний тухай загвар хуулиас⁷ жишээ аван хуулийн төслийг бэлтгэсэн бөгөөд уг загвар хуулийн 14 дүгээр зүйлд хэрвээ талууд маргаанаа шийдвэрлэн эвлэрлийн гэрээ байгуулсан нөхцөлд тус эвлэрлийн гэрээ нь заавал биелэгдэх шинжтэй байж болно хэмээн заасан. Харин манай улсын хувьд төсөл бэлтгэхдээ уг зохицуулалтыг оруулалгүй орхигдуулсан нь өнөөгийн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлах төвүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсны гол шалтгаан нөхцөл болж буй⁸ талаар судалгааны үр дүнгээс харж болохоор байна” гэжээ.

Тус зохицуулалтын хувьд хуулийн төсөл боловсруулагч (төсөл бичигч) хувийн эвлэрүүлэн зуучлалаар байгуулагдсан эвлэрлийн гэрээний гүйцэтгэл нь төвүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалд хүрсэн өнөөгийн нөхцөл байдлын нэг үндсэн шалтгаан болсон гэж тандан судалгааны дээрх дүгнэлтийг бататган онцолж байсан бол эвлэрүүлэн зуучлах төвд ажиллаж байсан төлөөллөөс авсан судалгааны ярилцлага, уулзалтын үеэр тус зохицуулалтын үр нөлөөтэй байдалд эргэлзээтэй хандаж байсаныг дурдах нь зүйтэй. Тэдний хувьд зээлийн мэдээллийн санд оруулах зэрэг бусад арга хэрэгсэл илүү үр дүнтэй байх болно гэж үзэж байна.

Тус асуудлаар дэлхийн зарим улс орнуудад эвлэрлийн гэрээг нотариатаар баталгаажуулах замаар гэрээний биелэлт хангагдах эрх зүйн орчныг бүрдүүлжээ. Тухайлбал, Оросын холбооны улсад эвлэрлийн гэрээг нотариатаар баталгаажуулсан тохиолдолд тухайн гэрээ шүүхийн шийдвэрийн

⁶ Хуулийн төслийн танилцуулгаас.

⁷ НҮБ-ийн Олон улсын худалдааны эрх зүйн комиссын цахим хуудас (Сүүлд үзсэн: 2024.02.26) <https://shorturl.at/mnrR7>

⁸ М.Мөнхнаран “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь”, УБ 2023 он., 25 дахь тал.

нэгэн адил биелэгдэх шинжтэй байхаар зохицуулжээ.⁹ Мөн Австри, Хойд Македон, Монтенегро, Словени улсуудад аливаа эвлэрлийн гэрээ нь шүүхээр эсхүл нотариатаар баталгаажаагүй тохиолдолд хэрэгжих боломжгүй байдаг байна.¹⁰ Өөрөөр хэлбэл улс орнууд нотариатаар дамжуулан эвлэрлийн гэрээг баталгаажуулах тогтолцоог хэдийнээ бүрдүүлжээ¹¹.

Харин манай улсад нотариатын мэдэгдэх хуудас шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл болдоггүйтэй холбоотойгоор аливаа эвлэрлийн гэрээг нотариатч гэрчлэн, нотариатын мэдэгдэх хуудас үйлдсэн хэдий ч шийдвэр гүйцэтгэх шатанд биеллээ олохгүй байх сул талтай гэж үзжээ¹². Тиймээс эвлэрлийн гэрээг нотариатчийн үйлдлээр баталгаажуулах хувилбарыг хэрэгжүүлэх тохиолдолд тухайн нотариатын баталгаажуулсан гэрээ нь шүүхийн шийдвэрийн нэгэн адил шууд биелэгдэх шинжтэй байх талаас нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн тодорхой заалтад нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй. Эвлэрлийн гэрээг нотариатийн мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэрээр баталгаажуулсан хэдий ч тус гэрээний гүйцэтгэл хангагдахын тулд шүүх дээр л баталгааждаг байх нь чанарын хувьд ялгаагүй нөхцөл байдалд хүргэнэ гэжээ.

Ийнхүү өмнөх судалгаанууд болон тандан судалгааны дүгнэлтээс үзэхэд хувийн эвлэрүүлэн зуучлах төвд хандаж эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд байгуулсан эвлэрлийн гэрээний үүрэг зөрчигдөхөд албадлага хэрэглэх боломжгүй, дахин шүүхэд хандах нөхцөл байдал үүсдэг нь хувийн эвлэрүүлэн зуучлалд хандаж маргаанаа шийдвэрлүүлэхгүй байх нэг үндсэн шалтгаан яах аргагүй болж байгаа бөгөөд шүүгчийн захирамжаар баталгаажуулах нь Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд тохирох гаргалгаа болж байна.

Үүнээс үзэхэд хуулийн төсөлд хувийн эвлэрүүлэн зуучлалаар байгуулсан эвлэрлийн гэрээний гүйцэтгэлтэй холбоотой заалт орсон нь хувийн эвлэрүүлэн зуучлалд итгэх итгэлийг нэмэгдүүлж, эвлэрүүлэн зуучлах төвд хандах тоог нэмэгдүүлэх хөшүүрэг болох боломжтой. Өөрөөр хэлбэл шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалд хандахтай харьцуулахад эвлэрүүлэн зуучлах төвд хандахад үүсдэг сул талыг тодорхой хэмжээнд арилгах, итгэл бий болгох үр нөлөөтэй.

3. Эвлэрүүлэн зуучлах төвийн зохион байгуулалт, үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг шинэчилж, магадлан итгэмжлэх тогтолцоог нэвтрүүлсэн зохицуулалтын ач холбогдол, үр нөлөө

⁹ Robert Rinatovich Izmailov (2020) “Mediation in Russia: Law Enforcement Issues, Tendencies and Prospects” p.5

¹⁰ Comparative Study of the legal and institutional frameworks and best practices on commercial mediation with recommendations for the Republic of Serbia (2021)., p.139.

¹¹ Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлангаас, хуудас 38.

¹² Мөн тэнд.

Хуулийн төсөлд эвлэрүүлэн зуучлах төвийг магадлан итгэмжлэх тогтолцоог нэвтрүүлсэн.

Хуулийн төслийн 8.1.Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу тухайн салбарын эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх энэ хуульд заасан журмын дагуу магадлан итгэмжлэгдсэн эвлэрүүлэн зуучлах төв/цаашид “Төв” гэх/-ийг ажиллуулж болно.

Хуулийн төслийн 8.3.Төвийг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Эвлэрүүлэн зуучлалын хороо/цаашид “Хороо” гэх/-ны саналыг үндэслэн магадлан итгэмжилнэ.

Хуулийн төслөөр одоо хэрэгжиж байгаа хуулийн 8 дугаар зүйлийг “Шүүхийн бус эвлэрүүлэн зуучлал” гэж нэр томъёог өөрчлөн найруулсан бөгөөд шүүхийн бус эвлэрүүлэн зуучлал нь “Эвлэрүүлэн зуучлах төв”-өөр дамжин явагдаж, төв нь хуулийн этгээдийн эрхгүй аль нэг байгууллагын дэргэд, эсхүл төрийн бус байгууллагын хэлбэрээр хуулийн этгээдийн эрхтэй байхаар өөрчилсөн. Өөрөөр хэлбэл эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг зөвхөн төвөөр дамжуулж явуулах бөгөөд хувь эвлэрүүлэн зуучлагч дангаар эвлэрүүлэн зуучлал явуулахгүй байх зохицуулалт бий болгож байна.

Харин эвлэрүүлэн зуучлах төвийг Хууль зүйн сайд магадлан итгэмжлэх бөгөөд Хууль зүйн яамнаас байгуулагдсан Эвлэрүүлэн зуучлалын хороо сайдад санал хүргүүлнэ. Мөн шүүхийн бус эвлэрүүлэн зуучлах төвд ажиллах эвлэрүүлэн зуучлагчид зөвшөөрлийг Эвлэрүүлэн зуучлах хорооны саналыг үндэслэн сайд олгохоор тусгасан байна.

Эвлэрүүлэн зуучлалын зохицуулалтын тогтолцоо нь дэлхийн бусад улс орнуудад өөр өөр эрх бүхий этгээдэд хадгалагдаж, зохион байгуулагдаж байна. Хуулийн төсөлд *Хууль зүйн яамны харьяанд эвлэрүүлэн зуучлалын зохицуулалтын тогтолцоог төвлөрүүлж байгаа нь нэг төрлийн загвар бөгөөд* Турк, Итали зэрэг улсад эвлэрүүлэн зуучлалын зохицуулагч байгууллага нь хууль зүйн яамны харьяанд байдаг. Хууль зүйн яам нь эвлэрүүлэн зуучлалтай холбоотой бодлого тодорхойлж, хэрэгжилтийг хангах бөгөөд эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа явуулж буй төвүүд болон хувь хүмүүсийг бүртгэх, магадлан итгэмжлэх, сургах, эвлэрүүлэн зуучлагчтай холбоотой өргөдөл гомдлыг хүлээн авах зэрэг эрх хэмжээтэй байна¹³.

Улмаар хуулийн төслийн 10 дугаар зүйлээр Эвлэрүүлэн зуучлах төвд тавигдах шаардлага болон магадлан итгэмжлүүлэхэд бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт, болон хувь эвлэрүүлэн зуучлагчид зөвшөөрөл олгох процессын зохицуулалтыг тусгаж өгсөн. Эвлэрүүлэн зуучлах төвд тавигдах

¹³ Хуулийн төслийн танилцуулгаас.

шаардлагын тухайд Япон улсын туршлагыг харгалзан үзэж, тавигдах шаардлагуудыг тодорхойлсон байна¹⁴.

Ач холбогдол, үр нөлөөний хувьд тус зохицуулалт нь хувийн эвлэрүүлэн зуучлалд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлж, эвлэрүүлэн зуучлах төвүүдийн үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулсанаар төвд хандах тоог нэмэгдүүлэх боломжтой. Гэхдээ магадлан итгэмжлэх процесс, журам нь ойлгомжтой хялбар, тодорхой байж, хэрэгжсэн үед л эерэг үр нөлөө гарна гэдгийг онцлох нь зүйтэй. Ингэж хэрэгжиж чадаагүй тохиолдолд энэ нь эвлэрүүлэн зуучлах төвүүдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, үйл ажиллагаа явуулж эхлэх нэг ёсны аргамж болох бөгөөд хувийн эвлэрүүлэн зуучлалын төлөөлөлтэй хийсэн судалгааны уулзалт, ярилцлагын үеэр ч үүнийг мөн онцолж байлаа. Иймд судалгааны багийн зүгээс тус зохицуулалтын хэрэгжилтийг чухал ач холбогдолтой гэж үзэн судалгааны дараагийн хэсгүүдэд практикт хэрэгжих боломж, хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтүүдээр мөн давхан шалгасан болно.

Ийнхүү магадлан итгэмжлэлийн зохицуулалт нь иргэдэд эвлэрүүлэн зуучлалд итгэх итгэлийг тодорхой хэмжээнд бий болгох нь гарцаагүй боловч магадлан итгэмжлэх процесс, журам нь үйлчлүүлэгч, иргэдэд тодорхой байсанаар энэ зорилгод хүрнэ.

4. Төвд ажиллах эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйч бус байх боломж нээсэн зохицуулалтын ач холбогдол, үр нөлөө

Хуулийн төсөлд зөвхөн шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч эрх зүйч мэргэжилтэй байх бөгөөд Төвийн эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйч байх шаардлагагүй, өөр мэргэжлийн дээд боловсролтой байж болохоор зохицуулсан.

Хуулийн төслийн 14.1.Шүүхийн эвлэрүүлэн зуучлагч болон Төвийн эвлэрүүлэн зуучлагчид дараах шаардлага тавигдана:

14.1.1.эрх зүйн бүрэн чадамжтай байх;

14.1.2.дээд боловсролтой байх;

14.1.3.эвлэрүүлэн зуучлагчийн сургалтад хамрагдан гэрчилгээ авсан байх;

14.1.4.ял шийтгэлгүй байх/ял шийтгэгдэж байгаагүй.

14.3.Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч эрх зүйч мэргэжилтэй байна.

Ийнхүү шүүхийн бус эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйчээс өөр мэргэжилтэй байж болохоор зохицуулсан нь чухал ач холбогдолтой. Өмнө дурдсанчлан

¹⁴ Хуулийн төслийн танилцуулгаас.

хуулийн төсөлд зааснаар эвлэрүүлэн зуучлалын хөлсийг төв өөрөө, зах зээлийн зарчмаар тогтоох тул өндөр үнийн дүнтэй, бизнесийн нэр хүнд хадгалахыг хүссэн арилжааны маргаан болон нарийн мэргэжлийн ойлголт, мэргэжилтэн шаардах хэрэг маргаанууд эвлэрүүлэн зуучлах төвд хандах магадлал өндөртэй.

Ерөнхийдөө эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа амжилттай явагдах, цаашлаад талууд маргаанаа шүүхийн бус аргаар эвлэрүүлэн зуучлалд хандан шийдвэрлүүлэх хандлага төлөвшин тогтоход эвлэрүүлэн зуучлагчдын ур чадвар, мэргэшсэн байдал зэрэг нь ихээхэн нөлөө үзүүлдэг¹⁵. Мөн эвлэрүүлэн зуучлагчийн ур чадвар, мэдлэгээс шалтгаалан эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явагдах хэлбэр нь хоорондоо ялгаатай байдаг байна. Хэрэв тухайн ажиллагаанд эвлэрүүлэн зуучлагчаар оролцож буй этгээд нь эрх зүйн мэдлэгтэй, хуулийн хүрээнд талуудын маргаж буй гол асуудлыг үнэлэн шийдэл гаргах чадвартай байх тохиолдолд үнэлэх хэлбэрийн ажиллагаа явагддаг ба энэ нь ихэвчлэн шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд ажиглагдаж байна. Харин бусад тохиолдолд эвлэрүүлэн зуучлагч нь асуудлыг үнэлэх бус талуудыг өөрсдөө шийдэлд хүрэхэд дэмжлэг үзүүлэх замаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцдог ба энэ тохиолдолд эвлэрүүлэн зуучлагч нь тодорхой нэг салбарт мэргэшсэн этгээд байдаг. Энэ төрлийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь ихэвчлэн арилжааны маргааныг шийдвэрлэх хувийн эвлэрүүлэн зуучлах төвүүдэд явагддаг¹⁶.

Иймд төвийн эвлэрүүлэн зуучлагч эрх зүйчээс өөр мэргэжилтэй байж болохоор зохицуулсан нь хувийн эвлэрүүлэн зуучлалд томоохон давуу тал бий болгож байна. Энэ тухайд хувийн эвлэрүүлэн зуучлалын төлөөлөлтэй хийсэн судалгааны уулзалт, ярилцлагын үеэр оролцогчид мөн санал нийлж байсан. Харин хуулийн төсөл боловсруулагчийн зүгээс МҮХАҮТ, ШӨХТГ, МБХ, МББСБХ ТББ зэрэг байгууллагын дэргэд шүүхийн бус эвлэрүүлэн зуучлал байгуулагдах боломжтой гэж урьдчилсан байдлаар харж байгаа талаараа ярилцлагын судалгааны явцад онцолж байв.

Ийнхүү нь шүүхийн бус эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйчээс өөр мэргэжилтэй байж болохоор зохицуулсан нь төвүүдэд шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалаас давуу байдал үүсгэж байгаа гол зохицуулалтын нэг болж байна. Өөрөөр хэлбэл тус зохицуулалт нь эвлэрүүлэн зуучлах төвийн үйл ажиллагааг дэмжих зорилгод хүрэхэд эерэгээр нөлөөлнө гэж дүгнэлээ.

Хувийн эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх үндсэн зорилгод богино хугацаанд шууд хүрэх боломжгүй бөгөөд энэ нэгэнт зах зээлийн харилцаа, зарчмаар шийдвэрлэгдэх тул тодорхой хугацаа өнгөрсөний дараа хөгжлийн үе

¹⁵ Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлангаас, хуудас 39.

¹⁶ Мөн тэнд.

шатаараа явагдаж зорилгод хүрнэ гэж үзэж байна. Хуулийн төсөлд хувийн эвлэрүүлэн зуучлалд хандах магадлал, боломжийг нэмэгдүүлэх зохицуулалтуудын хөшүүргүүдийг боломжит хэмжээнд тусгаж өгсөн бөгөөд эдгээр нь хэрэгжих боломжтой, тодорхой үр дүн гаргахуйц зохицуулалтууд мөн боловч өнөөгийн нөхцөл байдал, түүхэн хөгжлийн байдлаас үзэхэд үндсэн зорилгод шууд богино хугацаанд хүрэх боломжгүй юм. Харин энэхүү зорилгод хүрэхэд төсөлд оруулсан хөшүүргийн шинж чанартай зохицуулалт, заалтууд нь хэр үр нөлөөтэй байгааг авч үзвэл маргааны төрөл, хамрах хүрээний хувьд боломжит хөшүүргүүд хангалттай хэмжээнд тусгагдсан бол төвийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын талаарх зохицуулалт нь үр нөлөөтэй хэрэгжихийн тулд магадлан итгэмжлэл болон төв байгуулахтай холбоотой асуудлыг тодорхой тусгах шаардлагатай байна. Харин улсын тэмдэгтийг буцаан олгох, хураамж хөнгөлөх зэрэг хөшүүргийн заалтууд нь хувийн эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх зорилгыг дэмжихэд үр нөлөө үзүүлж чадах эсэх нь эргэлзээтэй бөгөөд

Эцэст нь дээрх зохицуулалтуудын ач холбогдол, үр нөлөөг нэгтгэн дүгнэвэл хувийн эвлэрүүлэн зуучлал хөгжих эсэх нь цаг хугацааны явцад харагдана гэдэгтэй судалгааны явцад ерөнхийдөө бүгд санал нийлж байсан бөгөөд нэгэнт хувийн эвлэрүүлэн зуучлалд хандах тоо хэмжээ нь зах зээлийн зарчмаар шийдэгдэх тул саадыг арилгах, зах зээлийн төрлийн хөшүүргийг бий болгох нь чухал болж байна.

Ер нь хөгжлийн хувьд олон улсын туршлагаас харахад зохицуулалтаар дамжуулан шууд хөгжүүлэх боломжгүй бөгөөд тодорхой хугацааны дараа, хөшүүргүүд зөв тусгагдсан тохиолдолд зах зээлийн хэмжээ, хэрэг маргааны тоо зэргээс шалтгаалан тогтолцоо бий болж, хувийн эвлэрүүлэн зуучлал хөгждөг байна¹⁷.

Хуулийн төслийн хувьд хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд эвлэрүүлэн зуучлалд хандах боломжийг олгож, эвлэрүүлэн зуучлалд хандах болон эвлэрсэн зэргээс шалтгаалан тэмдэгтийн хураамжийг бууруулан төлөх, буцаан олгох, цахим болон утсаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд биечлэн оролцох, мөн төвүүд газар нутгийн харьяалал харгалзахгүй маргаан хүлээн авах болсон зэргээс үзэхэд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг нийтлэг байдлаар дэмжих, тэр дундаа төвүүдийн үйл ажиллагааг дэмжихэд шаардагдах үндсэн өгөгдөл (хөшүүрэг) болох зохицуулалтууд зохих хэмжээнд тусгагдсан байна.

Харин шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх, эвлэрүүлэн зуучлах төвд хандах хөшүүргийг тухайлан бий болгох хүрээнд дээр авч үзсэн зохицуулалтууд нь эвлэрүүлэн зуучлах төвд хандах тоо нэмэгдэх шууд үр дүн

¹⁷ “Making mediation law”, World bank publication, Mediation series, 2016. <https://documents1.worldbank.org/curated/en/899611503551941578/pdf/119067-WP-MakingMedLaw-PUBLIC.pdf>

богино хугацаанд гаргахгүй гэж үзэж байна. Гэхдээ төсөлд туссан бусад зохицуулалтын үр дүнд төвүүд нь зах зээлийн зарчмаар, шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалд хандах давуу талыг бий болгосноор эвлэрүүлэн зуучлах төвд хандах тоо нэмэгдэх үр дүн тодорхой хугацааны дараа гарах боломжтой.

Энэ хүрээнд хувийн эвлэрүүлэн зуучлалаар байгуулсан эвлэрлийн гэрээний гүйцэтгэлтэй холбоотой зохицуулалт болон магадлан итгэмжлэлийн зохицуулалт нь шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалд хандахтай харьцуулахад эвлэрүүлэн зуучлах төвд хандахад үүсдэг сул талыг тодорхой хэмжээнд арилгах, итгэл бий болгох үр нөлөөтэй байна. Харин шүүхийн бус эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйчээс өөр мэргэжилтэй байж болохоор зохицуулсан нь төвүүдэд шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалаас давуу байдал үүсгэх ач холбогдолтой байна.

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгагдсан зарим шинэ зохицуулалт нь дагаж мөрдөж, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг авч үзэх болно. Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг тооцохдоо хуулийн төслийг хэрэгжүүлэх мэргэжлийн байгууллага болох шүүх, Хууль зүй, дотоод хэргийн яам, шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлагч зэрэг төрийн байгууллагад үүрэг болгосон заалтыг хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар санал авч, үйл ажиллагааны тайлан болон тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар шалгалаа.

Аргачлалын дагуу практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг шалгаж тооцдог. Ингэхдээ дараах хоёр асуултад хариулах байдлаар тус шалгуур үзүүлэлтийг үнэлнэ. Үүнд:

1. Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх
2. Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх

Улмаар дээрх хоёр асуултад хариулах зарчмаар тус шалгуур үзүүлэлтээр судалгааны өмнөх шатанд сонгосон дараах зохицуулалтуудыг авч үзэж үнэллээ.

Хүснэгт 5. Практикт хэрэгжих боломжийг үнэлэх зохицуулалт

№	Практикт хэрэгжих боломжийг үнэлэх зохицуулалт	Сонгосон зүйл, заалт
1	Эвлэрүүлэн зуучлалын хорооны бүтэц, зохион байгуулалт Хуулийн төслийн 9.1; 9.2; 9.3; 9.4; 9.6	
2	Эвлэрүүлэн зуучлалын хорооны бүрэн эрх Хуулийн төслийн 9.5	
3	Шүүхийн бус эвлэрүүлэн зуучлал Хуулийн төслийн 8.1; 8.2; 8.3; 8.4; 8.5	
4	Эвлэрүүлэн зуучлах журмаар маргаан шийдвэрлэх харьяалал Хуулийн төслийн 6.5	
5	Эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангах Хуулийн төслийн 30.1; 30.2	

Иймд дээрх зохицуулалтуудыг чиглэл тус бүрээр нь хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг шалгаж дүгнэлээ.

1. Эвлэрүүлэн зуучлалын хорооны бүтэц, зохион байгуулалт

Хуулийн төслийн 9.1, 9.2, 9.3, 9.4, 9.6 дэх хэсэгт заасан эвлэрүүлэн зуучлалын хорооны бүтэц, зохион байгуулалт зохицуулалтын практикт хэрэгжих боломжид хийсэн дүн шинжилгээ

а). Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан Эвлэрүүлэн зуучлалын хорооны бүтэц, зохион байгуулалтыг тогтооход Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэх үндсэн субъект байна. Төслийн 9.3-т зааснаар хорооны бүрэлдэхүүнд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хоёр, шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, хуульчдын холбооны төлөөлөл, өмгөөлөгчдийн холбооны төлөөлөл, их дээд сургуулийн

багш тус бүр нэг байх бөгөөд хорооны гишүүний бүрэн эрх нэг удаа 4 жилийн хугацаатай байна. Түүнчлэн төслийн 9.4-т зааснаар Хороо бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх, Хорооны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах чиг үүрэг бүхий ажлын албатай байна. Хорооны ажлын албаны чиг үүргийг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэгж хэрэгжүүлнэ. Эндээс үзвэл эвлэрүүлэн зуучлалын хорооны бүтэц, зохион байгуулалттай холбогдох зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект хуулийн төсөлд тодорхой туссан байна.

б). Төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх

Хуулийн төслийн зохицуулалтаас харвал хороо бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх, Хорооны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах чиг үүрэг бүхий ажлын албатай байх ба Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэгж хэрэгжүүлэх чиг үүргийг хүлээж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны төлөөллөөс Эвлэрүүлэн зуучлалын хорооны ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх боломж, бололцоотой эсэхийг тодруулахад хуулийн төсөлд дурдсан Эвлэрүүлэн зуучлалын хороо нь Нотариатын мэргэшлийн хорооны үйл ажиллагаатай ижил төстэй байгаа тул энэ чиглэлд ажилласан туршлагатай болохоо илэрхийлж байв. Мөн төсөлд заасан ажлын албыг шинээр байгуулахтай холбоотойгоор хариуцах нэгж, ажлын байрны орон тоо нэмэх шаардлагагүй буюу төрд үүсэх ачаалал байхгүй байна. Тухайлбал ХЗДХЯ-ны холбогдох газар, хэлтэс нь одоогийн бүтэц, орон тоогоор, хуулийн төсөлд шинээр бий болж буй бүтэц болох Эвлэрүүлэн зуучлалын хорооны ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх боломжтой бөгөөд ХЗДХЯ тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх нь зохистой гэсэн байр суурьтай байна.

...ХЗДХЯ нь хууль тогтоомжид тусгайлан заасан чиг үүргийн дагуу нийт 6 төрлийн зөвшөөрөл олгож байна, ажлын ачаалал хэвийн гэж үзэж болно. Хэрэв Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгад заасан Эвлэрүүлэн зуучлалын хорооны ажлын албыг ХЗДХЯ-ны дэргэд байгуулвал 1 ахлах мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод нэмэлтээр тусган, хавсран гүйцэтгэх боломжтой. Тухайн ажилтны хариуцаж ажилладаг тамга тэмдгийн зөвшөөрөл нь цаасан суурьтай байх үед их ачаалалтай. Энэ жилээс цахим хэлбэрт шилжихээр төлөвлөсөн тул ААНБ-д алхам алхамаар мэдээллээ оруулаад Е Монголиагаар шалгагдаад зөвшөөрөл олгох товч дарах ба тус ажилтны ажлын ачаалал 30 хувиар буурахаар тооцоо гарсан. Манайд бичиг баримт их боловсруулах хэрэгцээ шаардлагатай байдаг чиг үүрэг нь Нотариат байгаа. Эвлэрүүлэн зуучлал явуулах зөвшөөрөл олгоно гэхээр Нотариаттай дүйцэхээр ачаалал үүснэ гэж ойлгож байна. Нотариатыг хариуцдаг мэргэжилтний ачааллаас харахад манайх энэ чиг үүргийг орон тоо нэмэлгүйгээр зохицуулаад явах боломжтой...

ХЗДХЯ-ны төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Түүнчлэн хуулийн төслийн талаар оролцогч талуудаас санал авах, уулзалт хийх явцад Эвлэрүүлэн зуучлалын хорооны бүтэц нь Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл эсхүл Нотариатын тухай хуулийн Нотариатын Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнтэй ижил, хуулбарласан шинжтэй байна гэж шүүмжилж байв. Харин арилжааны эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэхийг зорьж байгаа, хувийн эвлэрүүлэн зуучлах төвийн үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, магадлан итгэмжлэх чиг үүргийг хэрэгжүүлэх тул сэтгэл зүйч, бизнесийн байгууллагын төлөөллийг бүрэлдэхүүнд оруулах саналыг гаргаж байна. Мөн хорооны бүрэлдэхүүний бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байгаа нь оновчгүй буюу тодруулбал, 2 жилээс ихгүй байх эсхүл 4 жил байх нь зүй зохистой гэсэн үндэслэлээ тодорхой тайлбарлаагүй гэж үзэж байна.

2. Эвлэрүүлэн зуучлалын хорооны бүрэн эрх

Хуулийн төслийн 9.5 дэх хэсэгт заасан эвлэрүүлэн зуучлалын хорооны хэрэгжүүлэх бүрэн эрх зохицуулалтын практикт хэрэгжих боломжид хийсэн дүн шинжилгээ

а). Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт эвлэрүүлэн зуучлалын хорооны хэрэгжүүлэх бүрэн эрхийг тусгажээ. Өөрөөр хэлбэл эвлэрүүлэн зуучлалын хорооны бүрэн эрхийг хэрэгжүүлэх субъект нь эвлэрүүлэн зуучлалын хороо бөгөөд хуулийн төслийн үр дүнд шинээр бий болж буй бүтэц, орон тоо юм. Эвлэрүүлэн зуучлалын хороо нь Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгуулагдах тул хууль хүчин төгөлдөр болсноор Хууль зүй, дотоод хэргийн яам хороог байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх тул тус зохицуулалтыг хэрэгжүүлэх субьектийг хуулийн төсөлд тодорхойлж өгсөн байна.

б). Төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх

Эвлэрүүлэн зуучлалын хороо нь эвлэрүүлэн зуучлал явуулах зөвшөөрөл олгох, хүчингүй болгох санал гаргах; төвийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэлийг хүчингүй болгох санал гаргах, бүртгэл хөтлөх; төвийн үйл ажиллагаанд гаргасан гомдлыг шийдвэрлэх; төвд ажиллах эвлэрүүлэн зуучлагчийн ёс зүйн талаар гарсан гомдлыг шийдвэрлэх бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр байна.

Эвлэрүүлэн зуучлалын хороо нь хууль хүчин төгөлдөр болсноор бий болох шинэ бүтэц юм. Харин Эвлэрүүлэн зуучлалын хороо нь Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгуулагдаж, ажлын албатай байхаар хуулийн төсөлд тусгасан талаар өмнө дурдсан. Энэ дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамнаас төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг тодруулсан. Нотариатын тухай хуулийн дагуу Нотариатчийн мэргэшил, ур чадварын түвшинд дүгнэлт гаргах, мэргэшлийн шалгалт явуулах чиг үүрэг бүхий Мэргэшлийн хороо хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажилладаг байна. Хуулийн төсөлд туссан Эвлэрүүлэн зуучлалын хорооны үйл ажиллагааг Нотариатын мэргэшлийн хороотой төстэй бөгөөд энэ чиг үүргийг хэрэгжүүлэх боломжтой, туршлагатай болохоо ХЗДХЯ-ны төлөөлөл судалгааны явцад онцолсон. Харин төвийг магадлан итгэмжлэх бүрэн эрх нь харьцангуй шинэ бөгөөд өмнө нь энэ чиглэлд ажиллаж байгаагүй учир илүү нарийвчлан зохицуулах нь зүйтэй гэсэн байр суурийг илэрхийлж байв.

...Магадлан итгэмжлэх чиг үүргийг хэрэгжүүлсэн туршлага дутмаг. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль (2013)-д заасан Хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх чиг үүргийг Хуульчдын холбоо одоог хүртэл хэрэгжүүлж чадаагүй байна. Магадлан итгэмжлэл гэдэг нь өөрөө нарийн үе шаттай, тогтсон аргачлалтай үйл ажиллагаа гэж ойлгож байна. Манай яамны эмнэлэг гэхэд бүхэлдээ биш зөвхөн нэг тасгийн нэг үйлчилгээ нь ОУ-ын магадлан итгэмжлэл авсан байдаг. Тэгэхээр магадлан итгэмжлэл хийх бол ямар шалгуураар, юуг магадлан итгэмжлэх нь ойлгомжтой, тодорхой зохицуулалттай байх шаардлагатай...

ХЗДХЯ-ны төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Эвлэрүүлэн зуучлах төвийг магадлан итгэмжлэх нь төвийг хариуцлагажуулах замаар эвлэрүүлэн зуучлалаар үйлчлүүлж буй талуудад найдвартай үйл ажиллагаатай, итгэл төрүүлэхүйц байдлыг дэмжих зорилготой хөшүүрэг гэж хуулийн төслийн эхийг боловсруулагчид үзэж байна. Хэдий тийм боловч Эвлэрүүлэн зуучлалын хорооны бүрэн эрхэд хамаарах төвийг магадлан итгэмжлэх чиг үүргийг хэрэгжүүлэх туршлага хангалтгүй болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Иймд төвийг магадлан итгэмжлэх чиг үүрэг удаашрах, хэрэгжилт хангагдахгүй байх эрсдэл үүсч болох юм.

3. Шүүхийн бус эвлэрүүлэн зуучлал

Хуулийн төслийн 8.1, 8.2, 8.3, 8.4, 8.5 дэх хэсэгт заасан шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын төвийн зохицуулалтын практикт хэрэгжих боломжид


хийсэн дүн шинжилгээ

а). Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх

2015 болон 2020 онд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгааны хуулийн хэрэгжилт сайн буюу эерэг үр дүнтэй байна. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 7 болон 8 дугаар зүйлд Монгол Улсад эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагаа шүүхийн дэргэд болон шүүхээс гадуурх төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлах төвүүдэд хэрэгжих байдлаар заасан. Хэдий тийм боловч шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлал л үр дүнтэй хэрэгжиж байгаа буюу шүүхээс гадуурх байгууллагад эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хийгдэхгүй явж ирсэн.

2012 онд Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль батлагдсанаас хойш тус хуулийн 8 дугаар зүйлд заасан шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа явуулах хэд хэдэн албан ёсны эрх бүхий, мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчдын нэрсийн жагсаалттай эвлэрүүлэн зуучлах төвүүд нээгдсэн. Эдгээрээс дурьдвал Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Бизнесийн Маргааныг Эвлэрүүлэн Зуучлах Төв анх 2014 онд байгуулагдсан бөгөөд байгуулагдсан үеэсээ нийтэд хүрч үйл ажиллагаагаа амжилттай явуулж байжээ.

График 2. Танхимын дэргэдэх Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төвд ирсэн хүсэлт¹⁸



Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагааны тайлангаас үзвэл танхимын дэргэдэх Бизнесийн маргааныг

¹⁸ Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагааны тайлан, <https://www.mongolchamber.mn/p/543>

эвлэрүүлэн зуучлах төвд 2019 оноос хойш өргөдөл хүлээн аваагүй байна. Тус төв нь эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийн асуудлаас шалтгаалан шүүх дэх эвлэрүүлэн зуучлалыг бизнесийн маргаантай талуудад санал болгож байсан ба үүнийгээ дагаад иргэд, олон нийт тус төвд хандан үйлчилгээ авахаа больсон байна.¹⁹ Ийнхүү жил ирэх тусам тус төвд хандан шийдвэрлүүлэх хэргийн тоо буурсан нь талуудын хооронд байгуулагдсан эвлэрлийн гэрээний гүйцэтгэл буюу биелэлт байхгүйгээс эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар маргаанаа хянан шийдвэрлүүлсэн талууд дахин шүүхэд хандаж хөрөнгө мөнгө, цаг хугацаа алдах зэрэг сөрөг үр дагаварт хүргэж байсан.²⁰

Харин Монголын Олон Улсын Арбитраас Бизнесийн хэрэг, маргааныг шийдвэрлэх үйлчилгээ тасралтгүй үзүүлж иржээ.²¹

Хуулийн төсөлд зааснаар Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу тухайн салбарын эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх, магадлан итгэмжлэгдсэн эвлэрүүлэн зуучлах төвийг ажиллуулж болно. Төвийг аль нэг байгууллагын дэргэд хуулийн этгээдийн эрхгүй, эсхүл төрийн бус байгууллагын хэлбэрээр байгуулж болно гэж мөн уян хатан нөхцлөөр магадлан итгэмжлэх шаардлагыг нэмж тусгажээ.

Тодруулбал, хуулийн төслийн 8.2-д төв нь аль нэг байгууллагын дэргэд хуулийн этгээдийн эрхгүй, эсхүл төрийн бус байгууллагын хэлбэрээр хуулийн этгээдийн эрхтэй байж болно гэж заасан. Ингэснээр холбоо, хуулийн этгээдийн дэргэд байр, хүний нөөцийг ашиглан зардал багатайгаар байгуулах боломжийг гаргасан байна.

Харин хуулийн төсөлд заасан шаардлагыг хангаж, төв байгуулах сонирхол бүхий байгууллагын тоо хэмжээг шууд тооцож, тогтоох нь учир дутагдалтай буюу зах зээлийн зарчмын дагуу үүсч байгуулагдахаар байна. Энэ талаар хуулийн төсөл боловсруулагчийн зүгээс МҮХАҮТ, ШӨХТГ, МБХ, МББСБХ ТББ зэрэг байгууллагын дэргэд шүүхийн бус эвлэрүүлэн зуучлал байгуулагдах боломжтой гэж урьдчилсан байдлаар харж байгаа талаараа ярилцлагын судалгааны явцад онцолж байв.

Ажиллах эвлэрүүлэн зуучлагчдын тухайд авч үзвэл ЖАЙКА-ийн “Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төсөл”-ийн хүрээнд 2011-2015 онд нийт 7 удаагийн Эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх сургалтаар улсын хэмжээнд

¹⁹ М.Мөнхнаран “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь”, УБ 2023 он.

²⁰ Э.Санчир-Уяа “Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо дахь эвлэрүүлэн зуучлалд тулгамдаж буй асуудал”, УБ 2017 он., 4, 5 дахь тал.

²¹ Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагааны тайлан, (2015-2023) <https://www.mongolchamber.mn/p/543>

нийт 400 гаруй эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэж байжээ.²² Харин, Олон Улсын Эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO)-ын “Арилжааны эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх нь” төслөөс 2024-2025 онд Арилжааны эвлэрүүлэн зуучлагчийн сургагч багш бэлтгэх сургалтад шүүх, Өмгөөлөгчдийн холбоо, Монголын хуульчдын холбоо зэрэг байгууллагаас төлөөлөл хамруулан нийт 40 хүнийг бэлтгээд байна.

Эндээс үзвэл, төсөлд заасан шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын төв байгуулах, эхний ээлжийн түшиц болгох байгууллагуудыг чадавхжуулаагүй, харин эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх чиглэлд үйл ажиллагаа хийгдсэн байна. Өөрөөр хэлбэл хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээр ямар хугацаанд хичнээн төв байгуулагдах нь тодорхойгүй буюу хэрэгжүүлэх субъект байхгүй байна.

б). Төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх

Өмнө дурдсанчлан хуулийн төслийн 8 дугаар зүйлээр эвлэрүүлэн зуучлалын төв байгуулах боломжийг нээлттэй тавьж өгсөн гэж хуулийн төслийн эхийг боловсруулагчид үзэж байна.

Манай улсад 2006 оноос төрийн бус байгууллагыг түшиглэсэн эвлэрүүлэн зуучлах төв ажиллаж эхэлсэн бол 2010 оны 05 дугаар сараас 2012 оны 11 дүгээр сар хүртэлх хугацаанд Баянзүрх дүүргийн шүүх болон Дархан -Уул аймаг дахь Сум дундын шүүхийг түшиц шүүхээр сонгон, анх удаа шүүхийн дэргэд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг туршилтын журмаар явуулсан байдаг. Үүний дараагаар Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль 2012 оны 05 сарын 22-ны өдөр батлагдаж 2013 оны 04 сарын 15-аас хэрэгжиж эхэлснээр шүүх дэх эвлэрүүлэн зуучлал шүүх бүр дээр бий болж, үйл ажиллагаа явуулж байна.

...Бидний зүгээс төв байгуулаад ажиллах хүсэлтэй байна. Гэхдээ эвлэрүүлэн зуучлагч нар нь бүтэн цагаар ажиллах уу, тэдний цалин хөлс ямар байх, үйлчилгээний хөлсөө яаж тогтоох зэрэг асуудлыг уян хатан байдлаар зохион байгуулах боломжийг өгөх нь зүйтэй...

МҮХАҮТ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Хуучнаар Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төв МҮХАҮТ-ийн дэргэд үйл ажиллагаагаа явуулж байсан ба эвлэрлийн гэрээний гүйцэтгэл хангагдахгүй байснаар гүйцэтгэх хуудас бичсэн шүүгчийн захирамж гарах хэрэгцээ шаардлагын үүднээс үйлчлүүлэгчид шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд хандах болж тус төв үйл ажиллагаагаа зогсоосон байна. Иймд шүүхийн бус

²² Тунгалаг. (2014) Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг Монгол Улсад хөгжүүлэхэд эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн гүйцэтгэх үүрэг: үйл ажиллагаа, чиг хандлага. Хууль дээдлэх ёс. Улаанбаатар

эвлэрүүлэн зуучлалын төвөөс гаргасан эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангах асуудлыг хуульчилж өгснөөр төвийн үйл ажиллагаа сэргэнэ гэсэн хүлээлттэй буйгаа хуулийн төслийн эхийг боловсруулагчид онцолж байв.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэд үйл ажиллагаа явуулах эвлэрүүлэн зуучлал буюу шүүхийн бус эвлэрүүлэн зуучлах төвүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсон шалтгаан нь эвлэрүүлэн зуучлалын гэрээг баталгаажуулдаггүй, улмаар шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдах боломжгүй байсантай холбоотой байна. Мөн, шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалтай харьцуулахад зардал мөнгөний хувьд өндөр зэрэг шалтгаан нөхцөлтэй.

4. Эвлэрүүлэн зуучлах журмаар маргаан шийдвэрлэх харьяалал

Хуулийн төслийн 6.5 дэх хэсэгт заасан эвлэрүүлэн зуучлалыг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар хэрэглэх зохицуулалтын практикт хэрэгжих боломжид хийсэн дүн шинжилгээ

а). Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх

Төслийн 6 дугаар зүйлийн 6.5-д зааснаар гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаанаас гадна түрээс болон эд хөрөнгө хөлслөх гэрээний маргаан, хөршийн эрхийн маргаан, сууц өмчлөгчдийн холбооны маргаанд эвлэрүүлэн зуучлалыг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар хэрэглэхээр байна. Эндээс үзвэл эвлэрүүлэн зуучлалыг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар хэрэглэдэг маргааны төрөл зөвхөн гэр бүлийн эрх зүйн маргаанаар хязгаарлагдахаа больж нийт 4 төрлийн маргаан болж нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Урьдчилан шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлэх маргааны тоо²³

№		2022 он	2023 он	2024 он	Сүүлийн 3 жилийн дундаж
1	Түрээсийн гэрээтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэсэн тоо	626	608	695	643

²³ Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 2025 оны 03 сарын 13-ны өдрийн 01/429 тоот албан бичгийн хавсралт мэдээлэл, Хөршийн эрхтэй маргааныг бүртгэдэггүй тул тоон мэдээлэл гарах боломжгүй талаарх хариу бичигт дурдсан.

2	Эд хөрөнгө хөлслөх гэрээтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэсэн тоо	18	6	5	10
3	Сууц өмчлөгчдийн холбооны хэргийг хянан шийдвэрлэсэн тоо	829	725	683	746
4	Нийт	1473	1339	1383	1398

Эвлэрүүлэн зуучлалыг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар хэрэглэх маргааны төрөл нэмэгдсэнтэй холбоотойгоор эвлэрүүлэн зуучлалын эрэлт өсөх нь зайлшгүй. Хэдий тийм боловч шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын төв зах зээлийн зарчмаар байгуулагдахад тодорхой цаг хугацаа шаардагдах тул эхний хугацаанд шүүх дэх эвлэрүүлэн зуучлал эвлэрүүлэн зуучлалын урьдчилан шийдвэрлэх ажиллагааг бүхэлд нь хариуцан ажиллахаар байна.

Өөрөөр хэлбэл арилжааны эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх нэгэн хөшүүргийн хувьд урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэх маргааны төрлийг нэмэгдүүлсэн боловч шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын төвүүд зах зээлийн зарчмаар үүсч бий болох тул эхний ээлжинд шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд ачаалал үүсэхээр байна. Дээрх хүснэгтээс харахад, хуулийн төсөл батлагдсанаар жилд дунджаар 1400 орчим хэрэг маргаан шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчдад нэмэгдэн хуваарилагдаж очихоор байна.

Дүгнэж үзвэл хуулийн төсөлд заасан УША-аар шийдвэрлэх 4 төрлийн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг урьдчилан шийдвэрлэх журмаар хэрэгжүүлэх субъект нь эхний ээлжинд шүүх дэх эвлэрүүлэн зуучлал байна. Харин шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын төв ямар хугацааны дараа ажиллаж эхлэх, хэдэн эвлэрүүлэн зуучлалын төв байгуулагдах, иргэд, ААНБ-д шүүхийн бус эвлэрүүлэн зуучлах төвд хандах эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

б). Төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх

Эвлэрүүлэн зуучлалыг урьдчилан шийдвэрлэх ажиллагаагаар хэрэглэх 4 төрлийн маргааныг эхний ээлжинд шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч хүлээн авах нөхцөл байдал үүсч байгаа ч дээрх төрлийн маргаанд урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжтой болохоо шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид илэрхийлж байв.

...Хялбар ажиллагааны шүүх байгуулагдсантай холбоотойгоор тухайн шүүхийн эвлэрүүлэн зуучлагчид 13 саяас доош нэхэмжлэлийн үнийн дүнтэй маргааныг эвлэрүүлэх ажиллагаа хийж байгаа. Харин бусад шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид гэр бүлийн маргаан болон нэхэмжлэлийн үнийн дүн 13 саяас дээш маргаанд эвлэрүүлэн зуучлагчаар ажиллахаар байгаа. Тэгэхээр УША хийх 4 төрлийн маргааны хувьд Хялбар ажиллагааны шүүхийн эвлэрүүлэн зуучлагчид хүлээн авч шийдвэрлэнэ гэж үзэж байна. Мөн УША хийх 4 төрлийн маргааны хүрээнд нэмэгдэж буй маргааныг эвлэрүүлэхэд анхаарах зүйлийн талаар давтан сургалт орох шаардлагатай, дээрх маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжтой...

Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчтай хийсэн ярилцлагаас

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын 2 дугаар зүйлийн гурав дахь хэсэгт Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх байгуулахаар зааж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд холбогдох нэмэлтийг хийсэн байна. Тухайлбал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх нэхэмжлэлийг нийслэлд Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх харьяалан шийдвэрлэхээр, 751 дүгээр зүйлийн 75.11-д зааснаар Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах дараах нэхэмжлэлийг шүүгч дангаар тусгайлсан журмаар хянан шийдвэрлэхээр зохицуулсан байна. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулагдахаас өмнө хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх байгуулагдсан нь арилжааны эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх үйл ажиллагаанд зарим хязгаарлагдмал байдлыг үүсгэж байж болох юм. Тухайлбал, хуулийн төслийн эхний хувилбарт банк, банк бус санхүүгийн зээлтэй холбоотой хэрэг, маргаанд эвлэрүүлэн зуучлалыг урьдчилан шийдвэрлэх маргаанд харьяалуулж байсан бол тоог нь бууруулж эвлэрэх магадлал өндөртэй 4 маргааныг харьяалуулсан байна. Хялбар ажиллагааны анхан шатны шүүх нь шинэ тутам байгуулагдаж буй бүтэц тул зэрэгцсэн өөрчлөлтийг хууль тогтоомжид хийх нь эхний хуулийн хэрэгжилтэд нөлөөлөх эрсдэлтэй байж болох юм гэсэн байр суурийг ярилцлагын судалгаанд оролцсон шүүгчдийн төлөөлөл онцолж байв.

Мөн нөгөө талаас урьдчилан шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлэх 4 төрлийн маргаан нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 751 дүгээр зүйлийн 75.11-д зааснаар Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулахтай холбоотой маргаан бол Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн эвлэрүүлэн зуучлагчид хандахаар байна.

Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн тоон мэдээллээр тус шүүхэд 4 эвлэрүүлэн зуучлагч ажиллаж байгаа тул тэдгээр эвлэрүүлэн зуучлагчдыг арилжааны эвлэрүүлэн зуучлал чиглэлээр мэргэшүүлэх, мөн Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоонд үндэслэн орон тоог нэмэгдүүлэх шаардлага бий болж байна.

5. Эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангах

Хуулийн төслийн 30.1 дэх хэсэгт заасан эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангах зохицуулалтын практикт хэрэгжих боломжид хийсэн дүн шинжилгээ

а). Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх

Хуулийн төсөлд эвлэрүүлэн зуучлах төвийн эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг заавал баталгаажуулахгүй ба харин эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ сайн дураар биелүүлээгүй бол эвлэрлийн гэрээ зөрчигдөж эхэлсэн үеэс үүрэг гүйцэтгэгчийн харьяа дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүсэлт гарган эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулахаар зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангах, хангуулах субъект нь шүүхийн байгууллага, шүүгч байна.

Хүснэгт 7. Эвлэрлийн гэрээний гүйцэтгэл хангагдаж буй байдал, хувиар

	Шүүгчийн захирамжаар баталгаажуулсан эвлэрлийн гэрээ	Эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн захирамжид бичигдсэн гүйцэтгэх хуудасны тоо	Үүнээс хувь
2022 он	9280	6534	70%
2023 он	7948	6826	86%
2024 он	8158	6515	80%
Дундаж	8462	6625	78.2

Тус хүснэгтээс харахад эвлэрлийн гэрээний гүйцэтгэл хангалтгүй буюу сүүлийн 3 жилийн дунджаар 21.8 хувь байна. Энэ нь шүүгчийн захирамжаар

баталгаажуулсан 5 эвлэрлийн гэрээ тутмын 4 нь шүүхийн гүйцэтгэх хуудас бичих хэрэгцээ шаардлагатай болж буйг харуулж байна.

б). Төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх

Эвлэрүүлэн зуучлалын төвөөс ирүүлсэн эвлэрлийн гэрээг сайтар хянах хэрэгцээ шаардлага үүсч болзошгүй талаар шүүгчтэй хийсэн ярилцлагын үеэр онцоллоо. Түүнчлэн нөгөө талаас шүүхээр баталгаажуулах эвлэрлийн гэрээний загвар, маягтай байх нь зүйтэй гэсэн саналыг шүүхийн бус эвлэрүүлэн зуучлагч илэрхийлсэн байна.

Хүснэгт 8. Эвлэрлийн гэрээ баталгаажуулахаар ирүүлсэн материалыг шүүгчийн захирамжаар буцаасан тоо /үлсын хэмжээнд/

	Хүлээн авсан эвлэрлийн гэрээ	Үүнээс: Татгалзсан	Үүнээс хувь
2022 он	9375	95	
2023 он	8034	86	
2024 он	8034	86	
Дундаж	8481	89	0.01

Хүснэгтээс харахад эвлэрлийн гэрээ баталгаажуулахаар ирүүлсэн материалыг шүүгчийн захирамжаар буцаах явдал харьцангуй бага тохиолддог байна. Гэсэн хэдий ч шүүхийн бус эвлэрүүлэн зуучлагчдын хувьд шүүгчээр эвлэрлийн гэрээгээ баталгаажуулахад аливаа хүндрэл гарахаас сэргийлж стандарт гэрээний загвартай байх нь зүйтэй.

**3.3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд
үнэлсэн байдал**

Хуулийн төсөлд эвлэрүүлэн зуучлах төвийг магадлан итгэмжлэх тогтолцоог нэвтрүүлсэн. Иймд шинээр тусгагдсан төвүүдийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны чанарыг дээшлүүлэх, иргэдэд төвүүдэд хандах итгэл бий болгоход чиглэсэн магадлан итгэмжлэлтэй холбогдох зохицуулалт холбогдох этгээдүүдэд хүлээн зөвшөөрөгдөх эсэхийг энэхүү шалгуур үзүүлэлтээр шалгах

нь зүйтэй гэж үзлээ. Ингэхдээ эдгээр зохицуулалтыг холбогдох этгээдүүд хүлээн зөвшөөрч магадлан итгэмжлэх тогтолцоо бий болгох зохицуулалттай холбогдох заалтууд практикт хэрэгжих боломжтой эсэхийг шалгах юм.

Энэ хүрээнд эвлэрүүлэн зуучлалын хураамжийн асуудлыг мөн авч үзлээ.

Хуулийн төслийн 10.1. Дараах шаардлагыг хангасан Төв магадлан итгэмжлүүлэх хүсэлтийг Хорооны ажлын албанд гаргана:

- 10.1.1. таваас доошгүй эвлэрүүлэн зуучлалчтай;
10.1.2. үйл ажиллагаа явуулах ажлын байртай.

Хуулийн төслийн 10.2. Магадлан итгэмжлүүлэх хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргана:

- 10.2.1. эвлэрүүлэн зуучлах төвийн нэр, хуулийн этгээдийн дэргэд байгуулагдах бол тухайн хуулийн этгээдийн нэр, хаяг, тухайн эвлэрүүлэн зуучлах төвийг төлөөлөх эрх бүхийн этгээдийн овог нэр, хаяг;
10.2.2. эвлэрүүлэн зуучлах төвийн байрлах байрны хаяг, байршил;
10.2.3. хуулийн этгээдийн хэлбэрээр байгуулагдсан эвлэрүүлэн зуучлалын төв бол байгууллагын дүрэм;
10.2.4. төрийн болон ашгийн бус байгууллагын дэргэд байгуулагдаж буй эвлэрүүлэн зуучлах төв бол тухайн төрийн болон ашгийн бус байгууллагын дүрэм;
10.2.5. энэ хуулийн 10.3-т заасан шаардлагыг хангасан дүрэм холбогдох баримт бичиг;
10.2.6. төвийн үйл ажиллагааны төлөвлөгөө;

Хуулийн төслийн 10.3. Төвийн дүрэмд дараах зүйлсийг тусгана:

- 10.3.1. тухайн салбарт эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах маргааны төрөл, хүрээ;
10.3.2. маргааны талуудтай ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх арга, хэлбэр;
10.3.3. эвлэрүүлэн зуучлагчийг сонгох, татгалзах журам;
10.3.4. эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйч биш байх тохиолдолд эвлэрлийн гэрээ нь хууль зөрчөөгүй, гуравдагч этгээдийн эрхийг хөндөөгүй болохыг баталгаажуулах үүднээс хуульч, өмгөөлөгч оролцуулах журам;
10.3.6. маргааний талуудын хүсэлт гаргах загвар, бүрдүүлэх бичиг баримт;
10.3.7. эвлэрүүлэн зуучлах төвд хандаж хүсэлт гаргасан бол уригдагч талд энэ талаар мэдэгдэх арга, журам;
10.3.8. эвлэрүүлэн зуучлах төвийн баримт материал хадгалах, хамгаалах, буцаан өгөхтэй холбоотой журам;
10.3.9. эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нууцлалыг хадгалах, хамгаалах журам;
10.3.10. эвлэрүүлэн зуучлагч болон төвийн ажилтнууд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад олж мэдсэн нууцыг хадгалах, хамгаалах журам;
10.3.11. эвлэрүүлэн зуучлагч болон эвлэрүүлэн зуучлах төвийн үйл ажиллагааны зардал болон эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хөлс, хураамжийг тооцоолох аргачлал болон тэдгээрийн дүн, хөлс хураамж төлөх аргачлал;
10.3.12. эвлэрүүлэн зуучлах төвийн үйл ажиллагаанд гомдол гаргах журам.

Аргачлалын дагуу хүлээн зөвшөөрөгдөх байдлыг үнэлэх үндсэн арга нь тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдийн хандлага, санал бодлыг тандан мэдэж дүгнэлт гаргах арга зүй байдаг.

Энэ хүрээнд судалгааны явцад хийсэн уулзалт, ярилцлагаас хүлээн зөвшөөрөх байдалд хамаарах 2 үндсэн асуудал ажиглагдсан. Эдгээр нь нэгдүгээрт, зохицуулалтыг хэрэгжүүлэгчийн хувьд юуг магадлан итгэмжлэх гэж байгааг тодорхой болгох, хоёрдугаарт, зохицуулалтыг хэрэглэгчийн хувьд магадлан итгэмжлүүлэхэд тавигдах шаардлагыг тодорхой, хэрэгжүүлэгчийн зүгээс ялгаатай байдлаар хандах гаргах боломжгүй болгох гэсэн 2 асуудал болно.

Нэгдүгээр асуудал буюу зохицуулалтыг хэрэгжүүлэгчийн хувьд юуг магадлан итгэмжлэх гэж байгааг тодорхой болгох тухайд олон улсын жишиг болон Монгол Улсад хэрэгжиж байгаа практикаас үзэхэд магадлан итгэмжлэх [объект] нь тодорхой бөгөөд хүрээ багатай байх нь магадлан итгэмжлэх асуудал амжилттай хэрэгжихэд нөлөөлдөг талаар судалгааны явцад оролцогчид онцолж байлаа. Тухайлбал, ямарваа нэг хөтөлбөрийг магадлан итгэмжлэхэд тухайн хөтөлбөрийн агуулга, бүтцийг магадлан итгэмжилдэг. Харин магадлан итгэмжлэх зүйл нь тодорхойгүй болон өргөн хүрээнд байх нь амжилтгүй хэрэгжих нөхцөлд хүргэдэг байна. Үүнийг хууль зүйн сургуулийн магадлан итгэмжлэл хэрэгжихгүй байгаа туршлагаас харж болно²⁴.

Энэ талаарх хуулийн төслийн зохицуулалтыг авч үзвэл 10.1-д заасан таваас доошгүй эвлэрүүлэн зуучлагчтай, үйл ажиллагаа явуулах ажлын байртай байх үндсэн шаардлага хангасан эсэхийг шалгах, улмаар 10.2-д зааснаар дүрэм, үйл ажиллагааны төлөвлөгөөг үнэлж магадлан итгэмжлэх, ингэхдээ дүрэм нь 10.3-д заасан зүйлсийг тусгасан эсэхэд үндэслэнэ гэж ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл үндсэндээ тухайн төвийн дүрмийг магадлан итгэмжлэх байдлаар зохицуулагдсан байна.

Харин дүрэмд тусгах зүйлс маргааны талуудтай ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх арга, хэлбэр, эвлэрүүлэн зуучлагчийг сонгох, татгалзах журам, эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйч биш байх тохиолдолд эвлэрлийн гэрээ нь хууль зөрчөөгүй, гуравдагч этгээдийн эрхийг хөндөөгүй болохыг баталгаажуулах үүднээс хуульч, өмгөөлөгч оролцуулах журам, маргааны талуудын хүсэлт гаргах загвар, бүрдүүлэх бичиг баримт, эвлэрүүлэн зуучлах төвд хандаж хүсэлт гаргасан бол уригдагч талд энэ талаар мэдэгдэх арга, журам, эвлэрүүлэн зуучлах төвийн баримт материал хадгалах, хамгаалах, буцаан өгөхтэй холбоотой журам, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны нууцлалыг хадгалах, хамгаалах журам, эвлэрүүлэн зуучлагч болон төвийн ажилтнууд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад олж мэдсэн нууцыг хадгалах,

²⁴ Энэ тохиолдолд магадлан итгэмжлэл сургуулийн материаллаг бааз, хүний нөөц, хөтөлбөр г.м олон зүйлийг хамарч байгаа.

хамгаалах журам, эвлэрүүлэн зуучлагч болон эвлэрүүлэн зуучлах төвийн үйл ажиллагааны зардал болон эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хөлс, хураамжийг тооцоолох аргачлал болон тэдгээрийн дүн, хөлс хураамж төлөх аргачлал, эвлэрүүлэн зуучлах төвийн үйл ажиллагаанд гомдол гаргах журам зэргийг хамарч байна.

Эдгээр нь улмаар энэ зохицуулалтыг хэрэглэгчийн хувьд магадлан итгэмжлүүлэхэд тавигдах шаардлага нь тухайн сонгуулийн жилд ажиллаж байгаа хариуцсан яамны бодлого, чиглэлээс шалтгаалан өөрчлөгдөх боломж, хэрэгжүүлэгчийн зүгээс ялгаатай байдлаар хандах эрсдэлийг үүсгэж байна гэж судалгааны явцад холбогдох этгээдүүд шүүмжлэлтэй хандаж байлаа.

Иймд Хоёрдугаарт, зохицуулалтыг хэрэглэгчийн хувьд магадлан итгэмжлүүлэхэд тавигдах шаардлагыг тодорхой болгож, өөрчлөгдөх боломжийг багасгах, хэрэгжүүлэгчийн зүгээс ялгаатай байдлаар хандах гаргах боломжгүй болгох асуудал тус зохицуулалтын хүрээнд тавигдаж байна. Энэ тухайд магадлан итгэмжлүүлэх дүрэмд тусгах зүйлс нь нэг талаас уян хатан шинжтэй боловч нөгөө талаас төслийн 10.4-д төвийн дүрмийн жишиг загварыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах тул жишиг загвар батлах бүрд дагаад шаардлага өөрчлөгдөх магадлалтай гэж үзэж байна.

Түүнчлэн төвийг 5 жилийн хугацаагаар магадлан итгэмжлэхээр тусгасан боловч 5 жилийн дараа дахин магадлан итгэмжлэл авах шаардлага нь шинээр авах процесстой ижил эсхүл хялбар байх талаар тухайлсан зохицуулалт тусгагдаагүй байна. Иймд зохицуулалтыг төв байгуулж буй талд ойлгомжтой болгох нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн магадлан итгэмжлэх шаардлагатай холбоотойгоор таваас доошгүй эвлэрүүлэн зуучлагчтай байх шаардлагыг мөн оролцогчид шүүмжлэлтэй хүлээж авч байсан болно. Ярилцлагад оролцсон хувийн эвлэрүүлэн зуучлалын төлөөлөл тус шаардлагыг биелүүлэхэд хүндрэл үүснэ гэж үзэж байна.

Харин 10.1-д заасан үйл ажиллагаа явуулах ажлын байртай байх үндсэн шаардлагын хувьд хуулийн төслийн 8.2-д төв нь аль нэг байгууллагын дэргэд хуулийн этгээдийн эрхгүй, эсхүл төрийн бус байгууллагын хэлбэрээр хуулийн этгээдийн эрхтэй байж болно гэж заасан нь тус шаардлагыг хэрэгжүүлэхэд эерэг нөлөөтэй байна. Учир нь ийнхүү аль нэг байгууллагын дэргэд хуулийн этгээдийн эрхгүй байж болохоор заасан нь холбоо, хуулийн этгээдийн дэргэд байр, хүний нөөцийг ашиглан зардал багатайгаар байгуулах боломжийг олгох зорилготой байна.

Эвлэрүүлэн зуучлалын хураамж

Эвлэрүүлэн зуучлалын давуу тал бол түргэн шуурхай, зардал багатайгаар маргаанаа шийдвэрлэх байдаг. Зардал багатай гэдэг нь маргааны талуудад бусад маргаан шийдвэрлэх албан ёсны механизм болох шүүхийн процесст оролцохоос бага зардал гарахаар байхыг ойлгоно. Шүүх хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэхэд гурван шатны шүүхийн бүтэц ажиллах, хатуу тогтоосон процессын журмын дагуу ажиллагаа хийгдэх, шүүхийн шат болгонд улсын тэмдэгтийн хураамж төлөх, нарийн процессын журам тогтоосон байдаг тул мэргэшсэн өмгөөлөгч хуульч ажиллуулах хэрэгцээ шаардлага гарах, хатуу тогтсон процессын журам, шүүхийн ажлын ачааллаас хамаарч цаг хугацаа их зарцуулдаг зэрэг олон хүчин зүйлээс хамаарч шүүхээр маргаанаа шийдвэрлүүлэх зардал өндөртэй байдаг. Үүнтэй харьцуулахад эвлэрүүлэн зуучлал нь талууд өөрсдөө маргаанаа шийдвэрлэх тул хүний нөөцийн зардал бага, эвлэрлийн гэрээ байгуулсан бол давж заалдах шатгүй, шүүхийн процессын хууль шиг хатуу тогтоосон процессын нарийн журамгүй тул түргэн шуурхай байх боломжтой зэрэг олон давуу талтай байна.

Монгол Улсад шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр талууд маргаанаа шийдвэрлүүлэх тохиолдолд Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7(1) дугаар зүйлийн 7(1).1 дэх хэсэгт заасны дагуу 30000 төгрөгийн хураамжтай байхаар тогтоосон байна. Өөрөөр хэлбэл маргааны үнийн дүнгээс үл хамааран бүх маргаанд тэмдэгтийн хураамжид 30000 төгрөг байхаар зохицуулжээ. Энэ нь шүүхийн улсын тэмдэгтийн хураамжтай харьцуулахад 1.300.000 төгрөгөөс доош үнийн дүнтэй маргаанд шүүхэд төлөх улсын тэмдэгтийн хураамжаас өндөр байх боловч, 1.300.000 мянгаас дээш үнийн дүнтэй маргааны хувьд шүүхэд төлөх улсын тэмдэгтийн хураамжаас эвлэрүүлэн зуучлалын тэмдэгтийн хураамж бага байна. Эвлэрүүлэн зуучлалын зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 07 дугаар тогтоолоор “Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны журам”-ийг шинэчлэн баталсан бөгөөд шинэчлэн батлагдсан журмын 27.4.6 хэсэгт 1.300.000 төгрөгөөс бага үнийн дүнтэй маргаанд Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7.1.1-т заасан хэмжээгээр тэмдэгтийн хураамж төлөхөөр зохицуулж өгсөн байна. Өөрөөр хэлбэл 1.300.000 төгрөгөөс доош үнийн дүнтэй маргаанд эвлэрүүлэн зуучлалын тэмдэгтийн хураамжийг 30 мянган төгрөгөөс бага байхаар журамлаж өгсөн байна.

Түүнчлэн шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд үнийн дүн өндөр, хэдэн тэрбумын шаардлага бүхий маргаанд эвлэрэх тохиолдол цөөнгүй, үүнд ч мөн адил улсын тэмдэгтийн хураамж 30 мянган төгрөг байгаа нь хэт бага гэх шүүмжлэл байна. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль 2012 оноос хойш хэрэгжээд даруй 12 жил болсон ч улсын тэмдэгтийн хураамжийг эдийн засгийн нөхцөл байдал, инфляцитай уялдуулах байдлаар шинэчлэн тогтоогоогүй байна. Үүнээс дүгнэж үзвэл шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын тэмдэгтийн хураамжийг интервалтай болгох, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан тэмдэгтийн хураамжийг шинэчлэн тогтоох хэрэгцээ шаардлагатай байна.

Харин төрийн болон төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлагчийн тусламжтайгаар маргаанаа шийдвэрлүүлсэн тохиолдолд ажлын хөлс, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хөлс зэргийг төлөх шаардлагатай. Эвлэрүүлэн зуучлах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн зардал, ажлын хөлсийг талууд гэрээгээр тохиролцоно” гэж зааж өгсөнөөс өөрөөр шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын хураамж, зардал, хөлсний талаар зохицуулалтыг хуульд тусгаж өгөөгүй байна. Практикт эвлэрүүлэн зуучлах төвүүд ажиллагааны хөлс, хураамжийг хэрхэн тооцдог байсныг авч үзвэл Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төв үйл ажиллагаагаа явуулж байхдаа өөрийн дотоод дүрмээрээ эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зардлыг тогтоож мөрдүүлж байжээ. Ингэхдээ 1-ээс 10 сая хүртэлх үнийн дүнтэй маргаанд 100 мянган төгрөг, 10-аас 100 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй маргаанд 250 мянган төгрөг, 100 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй маргаанд 500 мянган төгрөг, эд хөрөнгийн бус мөнгөн дүнгээр үнэлэх боломжгүй маргаанд 200 мянган төгрөгөөр тооцож зардлыг төлүүлдэг байжээ. Гэвч тус дүрэмд дээрх зардлыг хэрхэн төлөх, хэзээ төлөх, хэрхэн хуваарилах талаар нарийвчилсан зохицуулалтыг дүрэмдээ тусгаж өгөөгүй байна.

Манай Улсын хувьд зөвхөн шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын хураамжийн асуудлыг зохицуулж, шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлалын хураамжийн талаар нарийвчлан тогтоогоогүй байгаа нь тус хувийн эвлэрүүлэн зуучлалын салбар зах зээлийн зарчмынхаа дагуу өөрөө хөгжих боломжийг олгосон гэж үзэж болох юм. Харин эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явагдахад хураамжийг хэзээ, яаж, хэрхэн төлөх эсэх асуудлыг нарийвчлан тогтоогоогүй байгаа нь бусад маргаан шийдвэрлэх аргуудтай харьцуулахад тодорхойгүй нөхцөл байдлыг бий болгож байна. Тиймээс эвлэрүүлэн зуучлалаар дамжуулан маргаанаа хянан шийдвэрлүүлэхэд ямар зардал үүсэх, түүнийг ажиллагааны аль шатанд төлөх зэрэг нь тодорхой болгох шаардлагатай байгаа бөгөөд энэ нь цаашлаад эвлэрүүлэн зуучлалыг сонгох хүмүүсийн тоог нэмэгдүүлж, эвлэрүүлэн зуучлалыг идэвхжүүлэхэд эерэг нөлөөтэй байна.

3.4. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой томъёологдсон эсэхийг авч үзэв. /Хуулийн төсөл 6 бүлэг, 40 зүйлтэй./

Хүснэгт 9. Хуулийн төслийн ойлгомжгүй томъёологдсон зохицуулалтын түүвэр

№	Хуулийн төслийн ойлгомжгүй байгаа зохицуулалт	Тайлбар
---	---	---------

1	9.4.Хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.4.2.Төвийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох санал гаргах, бүртгэл хөтлөх;	Төвийг магадлан итгэмжлэх нь Хорооны чиг үүрэг мэт ойлгогдож байна. Иймд ... талаар санал гаргах болгон найруулах Эвлэрүүлэн зуучлах төвийг Хууль зүйн сайд магадлан итгэмжлэх бөгөөд хороо сайдад санал хүргүүлнэ.
2	21.5.Шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө талууд эвлэрүүлэн зуучлалд хандаж, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд идэвх санаачилгатай оролцсон боловч эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй дуусгавар болсон бол шүүхийн улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг 25 хувиар бууруулж төлнө.	Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд идэвх санаачилгатай оролцсон гэж үзэх талаар: Идэвх санаачилгатай оролцсон гэж үзэх үндэслэлийг тогтоох нь зүйтэй гэж үзэж байна.
3	27.1.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах хэлбэр нь уулзалт байна. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эхний уулзалтад талуудыг заавал оролцуулна. 28.1.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эхний уулзалтад талуудыг заавал оролцуулна. Энэ уулзалтаар эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэн зуучлалын талаарх ойлголт, онцлог, ажиллагааны журам, талуудын эрх үүргийг танилцуулж, талуудын шаардлага, тайлбарыг сонсоно.	Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эхний уулзалтад талуудыг заавал оролцуулна. 2 заалтад давтсан байна. Энэ нь давталоги, бичилтийн алдаатай харагдуулж байна.
4	14.1.Шүүхийн эвлэрүүлэн зуучлагч болон Төвийн эвлэрүүлэн зуучлагчид дараах шаардлага тавигдана: 14.1.1.эрх зүйн бүрэн чадамжтай байх; 14.1.2.дээд боловсролтой байх; 14.1.3.эвлэрүүлэн зуучлагчийн сургалтад хамрагдан гэрчилгээ авсан байх; 14.1.4.ял шийтгэлгүй байх/ял шийтгэгдэж байгаагүй.	Энэ шаардлага хангасан эвлэрүүлэн зуучлагч нь холбогдох нотлох баримтын хамт эвлэрүүлэн зуучлагчийн эрх авахаар хүсэлтээ Хорооны ажлын албанд гаргах тул эдгээр шаардлага нь нийтлэг шаардлага байна. (эсвэл төвийн эвлэрүүлэн зуучлагч нь эвлэрүүлэн зуучлагчийн эрх авсан байх шаардлага нэмж томъёолох)
5	11.1.Энэ хуульд заасан шаардлага хангасан эвлэрүүлэн зуучлагч нь холбогдох нотлох баримтын хамт эвлэрүүлэн зуучлагчийн эрх авахаар хүсэлтээ Хорооны ажлын албанд гаргана.	Шүүхийн эвлэрүүлэн зуучлагч шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын төвд ажиллаж болох эсэх нь зохицуулагдаагүй.

6	10.1.Дараах шаардлагыг хангасан Төв магадлан итгэмжлүүлэх хүсэлтийг Хорооны ажлын албанд гаргана: 10.1.1.таваас доошгүй эвлэрүүлэн зуучлагчтай; 10.1.2.үйл ажиллагаа явуулах ажлын байртай. 8.5.Төвд дээд боловсролтой, эвлэрүүлэн зуучлагчийн сургалтад хамрагдан эрх авсан, тухайн чиглэлийн асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах эвлэрүүлэн зуучлагчийн нэрсийн бүртгэлд бүртгэгдсэн мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулна.	Эрх авсан эвлэрүүлэн зуучлагч нь төвд харьяалагдахдаа орон тооны байх шаардлага тавигдах эсэх, хэд хэдэн төвд зэрэг ажиллах боломжтой эсэх нь тодорхой бус байна.
7	8.1.Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу тухайн салбарын эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх энэ хуульд заасан журмын дагуу магадлан итгэмжлэгдсэн эвлэрүүлэн зуучлах төв/цаашид “Төв” гэх/-ийг ажиллуулж болно. 10 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлалын төвийг магадлан итгэмжлэх 10.1.Дараах шаардлагыг хангасан Төв магадлан итгэмжлүүлэх хүсэлтийг Хорооны ажлын албанд гаргана:	Зуучлах төв болон зуучлалын төв гэсэн хоёр өөр нэршлээр хуульд тусгагдсан байна. Санал: Зуучлалын төв гэсэн нэршил нь Эвлэрүүлэн зуучлалын хороотой ижил, эвлэрүүлэн зуучлал хариуцсан төв мэт ойлгогдох магадлалтай тул зуучлах төв гэсэн нэршлийг дэмжиж байна.
	15.3.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд талууд биечлэн оролцох бөгөөд цахимаар, утсаар холбогдох байдлаар биечлэн оролцож болно. Хуулийн этгээд итгэмжлэлгүй төлөөлөх эрхтэй этгээд болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож болно. 21.7.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг талуудын хүсэлтээр цахимаар явуулж болно. 22.1.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг уг ажиллагааны хаалттай явагдах зарчмыг хангах боломжтой зориулалтын танхим, эсхүл талуудын тохиролцсон бусад газарт болон талуудын хүсэлтээр цахимаар явуулна.	15.3-д эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд талууд биечлэн оролцох бөгөөд цахимаар, утсаар холбогдох байдлаар биечлэн оролцож болно гэж заасан. 21.7, 22.1-д эвлэрүүлэн зуучлах ажиллагааг талуудын хүсэлтээр цахимаар явуулна гэсэн нь утсаар явуулах гэдэг нь зөвшөөрөгдөхгүй эсвэл цахимаар явуулахын нэг хэлбэр үү гэсэн ойлголтын эргэлзээ төрүүлж байна.

ДӨРӨВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Хуулийн төслийн үр нөлөөг шалгуур үзүүлэлт бүрээр дараах байдлаар үнэлж дүгнэлээ.

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төсөлд хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд эвлэрүүлэн зуучлалд хандах боломжийг олгож, эвлэрүүлэн зуучлалд хандах болон эвлэрсэн зэргээс шалтгаалан тэмдэгтийн хураамжийг бууруулан төлөх, буцаан олгох, цахим болон утсаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд биечлэн оролцох, мөн төвүүд газар нутгийн харьяалал харгалзахгүй маргаан хүлээн авах болсон зэргээс үзэхэд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг нийтлэг байдлаар дэмжих, тэр дундаа төвүүдийн үйл ажиллагааг дэмжихэд шаардагдах үндсэн өгөгдөл (хөшүүрэг) болох зохицуулалтууд зохих хэмжээнд тусгагдсан байна.

Харин шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх, эвлэрүүлэн зуучлах төвд хандах хөшүүргийг тухайлан бий болгох хүрээнд юуны өмнө УША-аар шийдвэрлэх маргааны төрлийг нэмсэн. Үүнээс гадна хувийн эвлэрүүлэн зуучлалын үр дүнд байгуулсан эвлэрлийн гэрээг шүүхээр баталгаажуулах, эвлэрүүлэн зуучлах төвийг магадлан итгэмжлэх тогтолцоог нэвтрүүлэх, шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлагч эрх зүйч бус мэргэжилтэй байх боломж олгосон зохицуулалт төсөлд тусгагджээ.

Эдгээр зохицуулалтыг чиглэл тус бүрээр нь ач холбогдол, үр нөлөөг нь авч үзэж, улмаар эдгээр нь нийтдээ шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын шинэ, үр нөлөөтэй зохицуулалтын тогтолцоог бий болгож, эвлэрүүлэн зуучлах төвүүдийн үйл ажиллагааг хөгжүүлэх түлхэц болж чадах эсэхийг нийтэд нь дүгнэлээ. Үүнд:

1. Хамрах маргааны төрлийг нэмэгдүүлэх зорилгоор УША-аар шийдвэрлэх маргааны төрлийг нэмэгдүүлсэн зохицуулалт

Хуулийн төсөлд эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх маргааны хамрах хүрээг нэмэгдүүлэх үүднээс УША-аар шийдвэрлэх маргааны төрлийг нэмсэнээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.4-т зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас үүссэн маргаанаас гадна 1) түрээс болон эд хөрөнгө хөлслөх гэрээний маргаан, 2) хөршийн эрхийн маргаан, 3) СӨХ-д холбогдох маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх болж байна.

Ач холбогдлын хувьд УША-аар шийдвэрлэх маргааны төрлийг нэмэгдүүлсэнээр эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх маргааны тоо шууд нэмэгдэх үр дагавартай. Үүнд, эд хөрөнгө хөлслөх гэрээтэй холбоотой хэргийг хянан шийдвэрлэсэн тоо сүүлийн 3 жилийн дунджаар 9.6 буюу 10 хүрэхгүй байгаа бол СӨХ-той холбоотой хэргийг хянан шийдвэрлэсэн тоо хамгийн олон буюу 3 жилийн дундаж 746, харин түрээсийн гэрээтэй холбоотой хэргийг

шийдвэрлэсэн тоо 3 жилийн дунджаар 643 байна. Иймд 3 төрлийн маргааныг шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоогоор нь баримжаалан нэгтгэн авч үзвэл 1 жилд ойролцоогоор 1400 орчим тооны маргаан УША-аар орох буюу эвлэрүүлэн зуучлалд хандахаар нэмэгдэж байна²⁵.

Үүнээс үзэхэд төвд хандах маргааны тоо эхний жилүүдэд нэмэгдэж буй²⁶ нийт маргааны 10%-д хүрэхгүй гэж үзвэл 5%-аар бодоход дор хаяж 70 маргаан хувийн эвлэрүүлэн зуучлалд хандах магадлал бий болж байна. Гэхдээ хувийн эвлэрүүлэн зуучлалд хэдэн хувь нь хандах тухайд шууд таамаглах боломжгүй юм. Хуулийн төсөлд зааснаар эвлэрүүлэн зуучлалын хөлсийг төв өөрөө, зах зээлийн зарчмаар тогтоох тул өндөр үнийн дүнтэй, бизнесийн нэр хүнд хадгалахыг хүссэн арилжааны маргаан болон нарийн мэргэжлийн ойлголт, мэргэжилтэн шаардах хэрэг маргаанууд эвлэрүүлэн зуучлах төвд хандах магадлал өндөртэй. Үүнийг манай улстай төстэй нөхцөл байдал үүссэн бусад орны туршлага ч харуулж байна.

Иймд УША-аар шийдвэрлэх маргааны төрлийг нэмэгдүүлснээр төвд хандах тоо нэмэгдэх шууд үр дүн богино хугацаанд гарахгүй гэж үзэж байна. Харин төсөлд туссан бусад зохицуулалтын үр дүнд төвүүд нь зах зээлийн зарчмаар, шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалд хандах давуу талыг бий болгосноор эвлэрүүлэн зуучлах төвд хандах тоо нэмэгдэх үр дүн тодорхой хугацааны дараа гарах боломжтой.

2. Хувийн эвлэрүүлэн зуучлалын үр дүнд байгуулсан гэрээг шүүхээр баталгаажуулах боломжтой болгосон зохицуулалт

Хуулийн төсөлд шүүхийн бус буюу эвлэрүүлэн зуучлах төвийн эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулах тухай тусгасан. Ингэхдээ эвлэрлийн гэрээ зөрчигдөж эхэлсэн үеэс анхан шатны шүүхэд хүсэлт гарган хувийн эвлэрүүлэн зуучлалаар байгуулсан эвлэрлийн гэрээг шүүгчийн захирамжаар баталгаажуулах боломжийг олгожээ.

Тус зохицуулалтын хувьд хуулийн төсөл боловсруулагч (төсөл бичигч) хувийн эвлэрүүлэн зуучлалаар байгуулагдсан эвлэрлийн гэрээний гүйцэтгэл нь төвүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалд хүрсэн өнөөгийн нөхцөл байдлын нэг үндсэн шалтгаан болсон гэдгийг онцолж байсан бол эвлэрүүлэн зуучлах төвд ажиллаж байсан төлөөллөөс авсан судалгааны ярилцлага, уулзалтын үеэр тус зохицуулалтын үр нөлөөтэй байдалд эргэлзээтэй хандаж байсаныг дурдах нь зүйтэй. Тэдний хувьд зээлийн мэдээллийн санд оруулах зэрэг бусад арга хэрэгсэл илүү үр дүнтэй байх болно гэж үзэж байна.

²⁵ Эдгээр нь зөвхөн шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоо бөгөөд үлдэгдэл буюу тухайн онд шийдвэрлэгдээгүй он дамжин үлдсэн маргааны тоо багтаагүй гэдгийг анхаарах нь зүйтэй.

²⁶ Гэр бүлийн маргаан нь одоо эвлэрүүлэн зуучлалаар УША-аар шийдэгдэж байгаа тул зөвхөн шинээр нэмэгдсэн маргааны төрлийн магадлалыг авч үзэв.

Харин өмнөх судалгаанууд болон тандан судалгааны дүгнэлтээс үзэхэд хувийн эвлэрүүлэн зуучлах төвд хандаж эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд байгуулсан эвлэрлийн гэрээний үүрэг зөрчигдөхөд албадлага хэрэглэх боломжгүй, дахин шүүхэд хандах нөхцөл байдал үүсдэг нь хувийн эвлэрүүлэн зуучлалд хандаж маргаанаа шийдвэрлүүлэхгүй байх нэг шалтгаан болж байгаа бөгөөд шүүгчийн захирамжаар баталгаажуулах нь Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд тохирох гаргалгаа гэж үзсэн байна.

Судалгааны багийн зүгээс ийнхүү хувийн эвлэрүүлэн зуучлалаар байгуулсан эвлэрлийн гэрээний гүйцэтгэлтэй холбоотой заалт орсон нь хувийн эвлэрүүлэн зуучлалд итгэх итгэлийг нэмэгдүүлж, эвлэрүүлэн зуучлах төвд хандах тоог нэмэгдүүлэх хөшүүрэг болох боломжтой гэж үзлээ. Өөрөөр хэлбэл шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалд хандахтай харьцуулахад эвлэрүүлэн зуучлах төвд хандахад үүсдэг сул талыг тодорхой хэмжээнд арилгах, итгэл бий болгох үр нөлөөтэй байна.

3. Эвлэрүүлэн зуучлах төвийн зохион байгуулалт, үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг шинэчилж, магадлан итгэмжлэх тогтолцоог нэвтрүүлсэн зохицуулалт

Хуулийн төсөлд эвлэрүүлэн зуучлах төвийг магадлан итгэмжлэх тогтолцоог нэвтрүүлсэн. Ингэхдээ одоо хэрэгжиж байгаа хуулийн 8 дугаар зүйлийг “Шүүхийн бус эвлэрүүлэн зуучлал” гэж нэр томъёог өөрчлөн найруулсан бөгөөд шүүхийн бус эвлэрүүлэн зуучлал нь “Эвлэрүүлэн зуучлах төв”-өөр дамжин явагдаж, төв нь хуулийн этгээдийн эрхгүй аль нэг байгууллагын дэргэд, эсхүл төрийн бус байгууллагын хэлбэрээр хуулийн этгээдийн эрхтэй байхаар өөрчилсөн. Өөрөөр хэлбэл эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг зөвхөн төвөөр дамжуулж явуулах бөгөөд хувь эвлэрүүлэн зуучлагч дангаар эвлэрүүлэн зуучлал явуулахгүй байх зохицуулалт бий болгож байна.

Ач холбогдол, үр нөлөөний хувьд тус зохицуулалт нь хувийн эвлэрүүлэн зуучлалд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлж, эвлэрүүлэн зуучлах төвүүдийн үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулсанаар төвд хандах тоог нэмэгдүүлэх боломжтой. Гэхдээ магадлан итгэмжлэх процесс, журам нь ойлгомжтой хялбар, тодорхой байж, хэрэгжсэн үед л эерэг үр нөлөө гарна гэдгийг онцлох нь зүйтэй. Ингэж хэрэгжиж чадаагүй тохиолдолд энэ нь эвлэрүүлэн зуучлах төвүүдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, үйл ажиллагаа явуулж эхлэх нэг ёсны аргамж болох бөгөөд хувийн эвлэрүүлэн зуучлалын төлөөлөлтэй хийсэн судалгааны уулзалт, ярилцлагын үеэр ч үүнийг мөн онцолж байлаа. Иймд судалгааны багийн зүгээс тус зохицуулалтын хэрэгжилтийг чухал ач холбогдолтой гэж үзэн судалгааны дараагийн хэсгүүдэд практикт хэрэгжих боломж, хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтүүдээр мөн давхан шалгасан болно.

Ийнхүү магадлан итгэмжлэлийн зохицуулалт нь иргэдэд эвлэрүүлэн зуучлалд итгэх итгэлийг тодорхой хэмжээнд бий болгох нь гарцаагүй боловч магадлан итгэмжлэх процесс, журам нь үйлчлүүлэгч, иргэдэд тодорхой байсанаар энэ зорилгод хүрнэ.

Төвд ажиллах эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйч бус байх боломж нээсэн зохицуулалт

Хуулийн төсөлд зөвхөн шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч эрх зүйч мэргэжилтэй байх бөгөөд Төвийн эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйч байх шаардлагагүй, өөр мэргэжлийн дээд боловсролтой байж болохоор зохицуулсан.

Тус зохицуулалтын хувьд өмнө дурдсанчлан хуулийн төсөлд зааснаар эвлэрүүлэн зуучлалын хөлсийг төв өөрөө, зах зээлийн зарчмаар тогтоох тул өндөр үнийн дүнтэй, бизнесийн нэр хүнд хадгалахыг хүссэн арилжааны маргаан болон нарийн мэргэжлийн ойлголт, мэргэжилтэн шаардах хэрэг маргаанууд эвлэрүүлэн зуучлах төвд хандах магадлал өндөртэй тул шүүхийн бус эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйчээс өөр мэргэжилтэй байж болохоор зохицуулсан нь чухал ач холболдолтой.

Ийнхүү төвийн эвлэрүүлэн зуучлагч эрх зүйчээс өөр мэргэжилтэй байж болохоор зохицуулсан нь хувийн эвлэрүүлэн зуучлалд томоохон давуу тал бий болгож байна. Энэ тухайд хувийн эвлэрүүлэн зуучлалын төлөөлөлтэй хийсэн судалгааны уулзалт, ярилцлагын үеэр оролцогчид мөн санал нийлж байсан. Харин хуулийн төсөл боловсруулагчийн зүгээс МҮХАҮТ, ШӨХТГ, МБХ, МББСБХ ТББ зэрэг байгууллагын дэргэд шүүхийн бус эвлэрүүлэн зуучлал байгуулагдах боломжтой гэж урьдчилсан байдлаар харж байгаа талаараа ярилцлагын судалгааны явцад онцолж байв.

Ийм шүүхийн бус эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйчээс өөр мэргэжилтэй байж болохоор зохицуулсан нь төвүүдэд шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалаас давуу байдал үүсгэж байгаа гол зохицуулалтын нэг болж байна. Өөрөөр хэлбэл тус зохицуулалт нь эвлэрүүлэн зуучлах төвийн үйл ажиллагааг дэмжих зорилгод хүрэхэд эерэгээр нөлөөлнө гэж дүгнэлээ.

Эцэст нь дээрх зохицуулалтуудын ач холбогдол, үр нөлөөг нэгтгэн дүгнэвэл хувийн эвлэрүүлэн зуучлал хөгжих эсэх нь цаг хугацааны явцад харагдана гэдэгтэй судалгааны явцад ерөнхийдөө бүгд санал нийлж байсан бөгөөд нэгэнт хувийн эвлэрүүлэн зуучлалд хандах тоо хэмжээ нь зах зээлийн зарчмаар шийдэгдэх тул саадыг арилгах, зах зээлийн төрлийн хөшүүргийг бий болгох нь чухал болж байна.

Хуулийн төслийн хувьд шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх, эвлэрүүлэн зуучлах төвд хандах хөшүүргийг тухайлан бий болгох хүрээнд дээр

авч үзсэн зохицуулалтууд нь эвлэрүүлэн зуучлах төвд хандах тоо нэмэгдэх шууд үр дүн богино хугацаанд гаргахгүй гэж үзэж байна. Гэхдээ төсөлд туссан бусад зохицуулалтын үр дүнд төвүүд нь зах зээлийн зарчмаар, шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалд хандах давуу талыг бий болгосноор эвлэрүүлэн зуучлах төвд хандах тоо нэмэгдэх үр дүн тодорхой хугацааны дараа гарах боломжтой.

Энэ хүрээнд хувийн эвлэрүүлэн зуучлалаар байгуулсан эвлэрлийн гэрээний гүйцэтгэлтэй холбоотой зохицуулалт болон магадлан итгэмжлэлийн зохицуулалт нь шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалд хандахтай харьцуулахад эвлэрүүлэн зуучлах төвд хандахад үүсдэг сул талыг тодорхой хэмжээнд арилгах, итгэл бий болгох үр нөлөөтэй байна. Харин шүүхийн бус эвлэрүүлэн зуучлагч нь эрх зүйчээс өөр мэргэжилтэй байж болохоор зохицуулсан нь төвүүдэд шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалаас давуу байдал үүсгэх ач холбогдолтой байна.

Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд 1) эвлэрүүлэн зуучлалын хорооны бүтэц, зохион байгуулалттай холбоотой заалтууд, 2) эвлэрүүлэн зуучлалын хорооны бүрэн эрхтэй холбоотой заалтууд, 3) шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалтай холбоотой заалтууд, 4) эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангахтай холбоотой заалтууд, 5) эвлэрүүлэн зуучлах журмаар маргаан шийдвэрлэх харьяалалтай холбоотой заалтыг сонгон авч “Практикт хэрэгжих боломж”-ийг тооцсон болно. Аргачлалын дагуу тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг шалгаж тооцдог. Иймд а). Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх; б). Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх гэсэн хоёр асуултад хариулах зарчмаар тус шалгуур үзүүлэлтээр үнэллээ.

1. Эвлэрүүлэн зуучлалын хорооны бүтэц, зохион байгуулалт

Хуулийн төслийн эвлэрүүлэн зуучлалын хорооны бүтэц, зохион байгуулалттай холбогдох зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект хуулийн төсөлд тодорхой туссан байна. Түүнчлэн тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжтой байна.

2. Эвлэрүүлэн зуучлалын хорооны бүрэн эрх

Хуулийн төслийн эвлэрүүлэн зуучлалын хорооны бүрэн эрхтэй холбогдох зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект болох хороо байхгүй, шинээр бий болох бүтэц байна. Харин хорооны ажлын албыг байгуулах ХЗДХЯ-ны хувьд эвлэрүүлэн зуучлалын хорооны бүрэн эрхтэй холбогдох зохицуулалтыг хэрэгжүүлэх боломжтой, Нотариатын мэргэшлийн хорооны чиг үүрэгтэй ижил

төстэй, хэрэгжүүлэх туршлагатай байна. Харин төвийг магадлан итгэмжлэх чиг үүрэг нь харьцангуй шинэ бөгөөд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байж болзошгүй, хэрэгжихгүй байх эрсдэлтэй зохицуулалт байна.

3. Шүүхийн бус эвлэрүүлэн зуучлал

Хуулийн төслийн шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалтай холбогдох зохицуулалтыг хэрэгжүүлэх субъектийг шууд бий болгох боломжгүй байна. Хуулийн төсөлд заасан шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын төв байгуулах, эхний ээлжийн түшиц болгох байгууллагуудыг чадавхжуулаагүй, харин эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх чиглэлд үйл ажиллагаа хийгдсэн байна. Өөрөөр хэлбэл хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээр ямар хугацаанд хичнээн төв байгуулагдах нь тодорхойгүй буюу хэрэгжүүлэх субъектын тоо тодорхойгүй байна.

4. Эвлэрүүлэн зуучлах журмаар маргаан шийдвэрлэх харьяалал

Эвлэрүүлэн зуучлалыг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар хэрэглэх маргааны төрөл нэмэгдсэнтэй холбоотойгоор эвлэрүүлэн зуучлалын эрэлт өсөх нь зайлшгүй. Хэдий тийм боловч шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын төв зах зээлийн зарчмаар байгуулагдахад тодорхой цаг хугацаа шаардагдах тул эхний хугацаанд шүүх дэх эвлэрүүлэн зуучлал эвлэрүүлэн зуучлалын урьдчилан шийдвэрлэх ажиллагааг бүхэлд нь хариуцан ажиллахаар байна.

Өөрөөр хэлбэл арилжааны эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх нэгэн хөшүүргийн хувьд урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэх маргааны төрлийг нэмэгдүүлсэн боловч шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын төвүүд зах зээлийн зарчмаар үүсч бий болох тул эхний ээлжинд шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд ачаалал үүсэхээр байна. Сүүлийн 3 жилийн дундаж дүнгээс үзэхэд хуулийн төсөл батлагдсанаар жилд дунджаар 1400 орчим хэрэг маргаан шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчдад нэмэгдэн хуваарилагдаж очихоор байна.

Шүүхээс гадуурх урьдчилан шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлэх 4 төрлийн маргаан нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75.11-д зааснаар Нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулахтай холбоотой маргаан бол Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн эвлэрүүлэн зуучлагчид хандахаар байна. Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн тоон мэдээллээр тус шүүхэд 4 эвлэрүүлэн зуучлагч ажиллаж байгаа тул тэдгээр эвлэрүүлэн зуучлагчдыг арилжааны эвлэрүүлэн зуучлал чиглэлээр мэргэшүүлэх, мөн Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоонд үндэслэн орон тоог нэмэгдүүлэх шаардлага бий болж байна.

5. Эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангах

Хуулийн төслийн эвлэрлийн гэрээний гүйцэтгэлийг хангахтай холбогдох зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект нь шүүхийн байгууллага, шүүгч байна.

Эвлэрүүлэн зуучлалын төвөөс ирүүлсэн эвлэрлийн гэрээг сайтар хянах хэрэгцээ шаардлага үүсч болзошгүй тул гүйцэтгэх хуудас бичихэд эвлэрлийн гэрээний загвар, маягттай байх нь зүйтэй байна.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төсөлд эвлэрүүлэн зуучлах төвийг магадлан итгэмжлэх тогтолцоог нэвтрүүлсэн. Иймд шинээр тусгагдсан төвүүдийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны чанарыг дээшлүүлэх, иргэдэд төвүүдэд хандах итгэл бий болгоход чиглэсэн магадлан итгэмжлэлтэй холбогдох зохицуулалт холбогдох этгээдүүдэд хүлээн зөвшөөрөгдөх эсэхийг энэхүү шалгуур үзүүлэлтээр шалгах нь зүйтэй гэж үзсэн болно.

Аргачлалын дагуу хүлээн зөвшөөрөгдөх байдлыг үнэлэх үндсэн арга нь тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдийн хандлага, санал бодлыг тандан мэдэж дүгнэлт гаргах арга зүй байдаг. Энэ хүрээнд судалгааны явцад хийсэн уулзалт, ярилцлагаас хүлээн зөвшөөрөх байдалд хамаарах 2 үндсэн асуудал ажиглагдлаа. Эдгээр нь нэгдүгээрт, зохицуулалтыг хэрэгжүүлэгчийн хувьд юуг магадлан итгэмжлэх гэж байгааг тодорхой болгох, хоёрдугаарт, зохицуулалтыг хэрэглэгчийн хувьд магадлан итгэмжлүүлэхэд тавигдах шаардлагыг тодорхой, хэрэгжүүлэгчийн зүгээс ялгаатай байдлаар хандах гаргах боломжгүй болгох гэсэн 2 асуудал болно.

Хуулийн төслийн зохицуулалтыг авч үзвэл 10.1-д заасан таваас доошгүй эвлэрүүлэн зуучлагчтай, үйл ажиллагаа явуулах ажлын байртай байх үндсэн шаардлага хангасан эсэхийг шалгах, улмаар 10.2-д зааснаар дүрэм, үйл ажиллагааны төлөвлөгөөг үнэлж магадлан итгэмжлэх, ингэхдээ дүрэм нь 10.3-д заасан зүйлсийг тусгасан эсэхэд үндэслэнэ гэж ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл үндсэндээ тухайн төвийн дүрмийг магадлан итгэмжлэх байдлаар зохицуулагдсан байна.

Харин төслийн 10.3-д заасан дүрэмд тусгах зүйлс энэ зохицуулалтыг хэрэглэгчийн хувьд магадлан итгэмжлүүлэхэд тавигдах шаардлага нь тухайн сонгуулийн жилд ажиллаж байгаа хариуцсан яамны бодлого, чиглэлээс шалтгаалан өөрчлөгдөх боломж, хэрэгжүүлэгчийн зүгээс ялгаатай байдлаар хандах эрсдэлийг үүсгэж байна гэж судалгааны явцад холбогдох этгээдүүд шүүмжлэлтэй хандаж байлаа.

Иймд зохицуулалтыг хэрэглэгчийн хувьд магадлан итгэмжлүүлэхэд тавигдах шаардлагыг тодорхой болгож, өөрчлөгдөх боломжийг багасгах, хэрэгжүүлэгчийн зүгээс ялгаатай байдлаар хандах гаргах боломжгүй болгох асуудал тус зохицуулалтын хүрээнд тавигдаж байна. Тодруулбал, магадлан итгэмжлүүлэх дүрэмд тусгах зүйлс нь нэг талаас уян хатан шинжтэй боловч нөгөө талаас төслийн 10.4-д төвийн дүрмийн жишиг загварыг хууль зүйн

асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах тул жишиг загвар батлах бүрд дагаад шаардлага өөрчлөгдөх магадлалтай гэж үзэж байна.

Түүнчлэн магадлан итгэмжлэх шаардлагатай холбоотойгоор таваас доошгүй эвлэрүүлэн зуучлагчтай байх шаардлагыг мөн оролцогчид шүүмжлэлтэй хүлээж авч байсан болно. Ярилцлагад оролцсон хувийн эвлэрүүлэн зуучлалын төлөөлөл тус шаардлагыг биелүүлэхэд хүндрэл үүснэ гэж үзэж байна. Харин 10.1-д заасан үйл ажиллагаа явуулах ажлын байртай байх үндсэн шаардлагын хувьд хуулийн төслийн 8.2-д төв нь аль нэг байгууллагын дэргэд хуулийн этгээдийн эрхгүй, эсхүл төрийн бус байгууллагын хэлбэрээр хуулийн этгээдийн эрхтэй байж болно гэж заасан нь тус шаардлагыг хэрэгжүүлэхэд эерэг нөлөөтэй байна. Учир нь ийнхүү аль нэг байгууллагын дэргэд хуулийн этгээдийн эрхгүй байж болохоор заасан нь холбоо, хуулийн этгээдийн дэргэд байр, хүний нөөцийг ашиглан зардал багатайгаар байгуулах боломжийг олгох зорилготой байна.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой томъёологдсон эсэхийг авч үзэв. /Хуулийн төсөл 6 бүлэг, 40 зүйлтэй./

№	Хуулийн төслийн ойлгомжгүй байгаа зохицуулалт	Тайлбар
1	9.4.Хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.4.2.Төвийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох санал гаргах, бүртгэл хөтлөх;	Төвийг магадлан итгэмжлэх нь Хорооны чиг үүрэг мэт ойлгогдож байна. Иймд ... талаар санал гаргах болгон найруулах Эвлэрүүлэн зуучлах төвийг Хууль зүйн сайд магадлан итгэмжлэх бөгөөд хороо сайдад санал хүргүүлнэ.
2	21.5.Шүүхэд нэхэмжлэл гаргахаас өмнө талууд эвлэрүүлэн зуучлалд хандаж, эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд идэвх санаачилгатай оролцсон боловч эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй дуусгавар болсон бол шүүхийн улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг 25 хувиар бууруулж төлнө.	Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд идэвх санаачилгатай оролцсон гэж үзэх талаар: Идэвх санаачилгатай оролцсон гэж үзэх үндэслэлийг тогтоох нь зүйтэй гэж үзэж байна.
3	27.1.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах хэлбэр нь уулзалт байна. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эхний уулзалтад	Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эхний уулзалтад талуудыг заавал оролцуулна.

	талуудыг заавал оролцуулна. 28.1.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны эхний уулзалтад талуудыг заавал оролцуулна. Энэ уулзалтаар эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэн зуучлалын талаарх ойлголт, онцлог, ажиллагааны журам, талуудын эрх үүргийг танилцуулж, талуудын шаардлага, тайлбарыг сонсоно.	2 заалтад давтсан байна. Энэ нь давталоги, бичилтийн алдаатай харагдуулж байна.
4	14.1.Шүүхийн эвлэрүүлэн зуучлагч болон Төвийн эвлэрүүлэн зуучлагчид дараах шаардлага тавигдана: 14.1.1.эрх зүйн бүрэн чадамжтай байх; 14.1.2.дээд боловсролтой байх; 14.1.3.эвлэрүүлэн зуучлагчийн сургалтад хамрагдан гэрчилгээ авсан байх; 14.1.4.ял шийтгэлгүй байх/ял шийтгэгдэж байгаагүй.	Энэ шаардлага хангасан эвлэрүүлэн зуучлагч нь холбогдох нотлох баримтын хамт эвлэрүүлэн зуучлагчийн эрх авахаар хүсэлтээ Хорооны ажлын албанд гаргах тул эдгээр шаардлага нь нийтлэг шаардлага байна. (эсвэл төвийн эвлэрүүлэн зуучлагч нь эвлэрүүлэн зуучлагчийн эрх авсан байх шаардлага нэмж томъёолох)
5	11.1.Энэ хуульд заасан шаардлага хангасан эвлэрүүлэн зуучлагч нь холбогдох нотлох баримтын хамт эвлэрүүлэн зуучлагчийн эрх авахаар хүсэлтээ Хорооны ажлын албанд гаргана.	Шүүхийн эвлэрүүлэн зуучлагч шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалын төвд ажиллаж болох эсэх нь зохицуулагдаагүй.
6	10.1.Дараах шаардлагыг хангасан Төв магадлан итгэмжлүүлэх хүсэлтийг Хорооны ажлын албанд гаргана: 10.1.1.таваас доошгүй эвлэрүүлэн зуучлагчтай; 10.1.2.үйл ажиллагаа явуулах ажлын байртай. 8.5.Төвд дээд боловсролтой, эвлэрүүлэн зуучлагчийн сургалтад хамрагдан эрх авсан, тухайн чиглэлийн асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах эвлэрүүлэн зуучлагчийн нэрсийн бүртгэлд бүртгэгдсэн мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулна.	Эрх авсан эвлэрүүлэн зуучлагч нь төвд харьяалагдахдаа орон тооны байх шаардлага тавигдах эсэх, хэд хэдэн төвд зэрэг ажиллах боломжтой эсэх нь тодорхой бус байна.
7	8.1.Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу тухайн салбарын эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх энэ хуульд заасан журмын дагуу магадлан итгэмжлэгдсэн эвлэрүүлэн зуучлах төв/цаашид “Төв” гэх/-ийг ажиллуулж болно. 10 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлалын	Зуучлах төв болон зуучлалын төв гэсэн хоёр өөр нэршлээр хуульд тусгагдсан байна. Санал: Зуучлалын төв гэсэн нэршил нь Эвлэрүүлэн зуучлалын хороотой ижил, эвлэрүүлэн зуучлал хариуцсан төв мэт ойлгогдох магадлалтай тул зуучлах

	төвийг магадлан итгэмжлэх 10.1.Дараах шаардлагыг хангасан Төв магадлан итгэмжлүүлэх хүсэлтийг Хорооны ажлын албанд гаргана:	төв гэсэн нэршлийг дэмжиж байна.
	15.3.Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд талууд биечлэн оролцох бөгөөд цахимаар, утсаар холбогдох байдлаар биечлэн оролцож болно. Хуулийн этгээд итгэмжлэлгүй төлөөлөх эрхтэй этгээд болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож болно. 21.7.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг талуудын хүсэлтээр цахимаар явуулж болно. 22.1.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг уг ажиллагааны хаалттай явагдах зарчмыг хангах боломжтой зориулалтын танхим, эсхүл талуудын тохиролцсон бусад газарт болон талуудын хүсэлтээр цахимаар явуулна.	15.3-д эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд талууд биечлэн оролцох бөгөөд цахимаар, утсаар холбогдох байдлаар биечлэн оролцож болно гэж заасан. 21.7, 22.1-д эвлэрүүлэн зуучлах ажиллагааг талуудын хүсэлтээр цахимаар явуулна гэсэн нь утсаар явуулах гэдэг нь зөвшөөрөгдөхгүй эсвэл цахимаар явуулахын нэг хэлбэр үү гэсэн ойлголтын эргэлзээ төрүүлж байна.

ХАВСРАЛТ

[Судалгааны захиалагчаа ирүүлсэн хуулийн төслийг хавсаргав]